



ГОВЬ АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“Алтай-Улиастай Эрчим Хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2016-2017 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭН, ҮР АШИГГҮЙ ЗАРДЛЫГ
БУУРУУЛСНААР, ХЭРЭГЛЭГЧДЭД ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧИЙГ
11.3 ТӨГРӨГӨӨР ХЯМД БОРЛУУЛАХ БОЛОМЖТОЙ БАЙНА.



Тайланг бэлтгэсэн:

Говь-алтай аймаг дахь
Төрийн аудитын газар

III баг

Дарга, Тэргүүлэх аудитор

Х.Түвшинбаяр
Утас: 99489309

Аудитын менежер
Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677

Ахлах аудитор
Д.Цэрэнханд
Утас:9914799

Аудитор
Г.Цэцэгмаа
Утас: 99489399

Аудитор
Х.Билэгбаяр
Утас: 94009818

Аудитор
М.Атарцэцэг
Утас: 88984411

2018 оны 09 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70483413,
70484055, 70484030
дугаарын утсаар харилцана
уу

Хаяг:
Говь-Алтай аймаг
Есөнбулаг сум
Баянхайрхан баг

Агуулга:

Товчилсон үгийн тайлбар:.....2
Хүснэгт, дүрслэлийн тайлбар:.....3
Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй,
шалгуур үзүүлэлт:.....4
Ерөнхий мэдээлэл:.....5-6
БҮЛЭГ I: Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэн,
хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчийг 11.3 төгрөгөөр хямд борлуулах
боломжтой байна.....7
1.1 Компанийн зорилтот түвшинд нийт зардал, алдагдлыг өндөр
төлөвлөсөн, энергийн мэдээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргаагүй
байна.....7
1.2 Аудитад хамрагдсан ажилчдын 28.5 хувь нь ажлын байрны
тодорхойлолтод заасан шаардлагуудыг хангахгүй
байна.....8
1.3 Компани санхүүгийн хувьд хараат, ашигт ажиллагааны хувьд
алдагдалтай ажилласан
байна.....9
1.4 Хүний нөөц, техникийн нөөцийг уялдуулан тооцсон хүчин чадлаар
ажиллавал ЦЭХ-ний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх боломжтой
байна.....10
1.5 Хэрэглэгчдэд ЦЭХ-ийг 11.3 төгрөг буюу одоо борлуулж байгаа
үнээс 12%-иар бууруулах боломжтой
байна.....11
1.6 Дотоод хяналт аудитын алба нь 2016 оныг эс тооцвол, техникийн
болон хөдөлмөр хамгааллын үйл ажиллагаанд хяналт тавьж
ажилласан байна.....11
БҮЛЭГ II: Үйл ажиллагааны бусад орлогыг нэмэгдүүлээгүй, хөрөнгийг
үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан
байна.....12
2.1 Үйл ажиллагааны бус орлогыг нэмэгдүүлээгүй, санхүүгийн
тайланд орлогыг зөрүүтэй тайлагнасан
байна.....12
2.2 Албан татвар, хураамжийг улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн
байна.....13
2.3 Хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгасан боловч, ТУЗ-ын тогтоол
шийдвэргүйгээр 4.5 сая төгрөгийн хөрөнгөөр охин компаниудыг
шагнасан байна.....14
2.4 Үр дүнгийн урамшуулалд 580.4 сая төгрөгийг давхардуулан
олгосон,ой, баяр ёслолын арга хэмжээнд 91.0 сая төгрөгийг үр
ашиггүй зарцуулсан
байна.....15
2.5 Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг журмын дагуу тооцсон
байна.....16
2.6 Санхүүгийн үйл ажиллагаа, зарцуулалтад дотоод хяналт
шалгалт хийгдээгүй
байна.....17
БҮЛЭГ III: Хөрөнгө оруулалтын ажлуудын 37 хувьд сонгон
шалгаруулалт хийгээгүй, зарим ажлын хэрэгжилт дутуу
байна.....17

3.1 Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлууд зайлшгүй шаардлагатай
байсан хэдий ч төлөвлөгөөнд тусгагдаагүй 262.4 сая төгрөгийн



	худалдан	авалт	хийсэн
	байна.....		17
3.2	Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлын 37 хувьд, төлөвлөгдөөгүй хөрөнгө оруулалтын ажлын 65 хувьд худалдан авалтын сонгон шалгаруулалт хийгээгүй байна.....		17
3.3	Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус, гэрээг дүгнээгүй, хүлээн авсан баримт материал хангалтгүй байна.....		18-19
3.4	Компанийн худалдан авах үйл ажиллагааны хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.....		20
	Дүгнэлт:.....		21
	Санал,Зөвлөмж:.....		22
	Илэрсэн зөрчлийн нэгтгэл		23-31
	Хавсралт:.....		32-
	Холбогдох байгууллагын санал:.....		
	Саналд өгсөн тайлбар:.....		



Товчилсон үгийн тайлбар

ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТӨЯХ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгсэл
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
АУЭХС	Алтай улиастайн эрчим хүчний систем
ББҮҮО	Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсний орлого
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний систем
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГАА	Говь-Алтай аймаг
МОУНТ	Монголын үндэсний олон нийтийн телевиз
МУЗГ	Монгол улсын засгийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НД	Нийгмийн даатгал
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
СЯ	Сангийн яам
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УЦС	Усан цахилгаан станц
ҮХХАТ	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ЦДҮС	Цахилгаан дамжуулан үндэсний систем
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХЯ	Эрчим хүчний яам

**Хүснэгт, дүрслэл, зургийн товъёог**

Хүснэгт №1	Хүний нөөц, түүнтэй холбоотой санхүүгийн нөөцийн судалгаа /сая.төг/
Хүснэгт №2	Энергийн мэдээ хүчин чадлын судалгаа /мян.квт цаг/
Хүснэгт №3	Татварын тайлангийн тулгалт /сая.төг/
Хүснэгт №4	Нэмэгдсэн үндсэн хөрөнгийн судалгаа /сая.төг
Хүснэгт №5:	Үндсэн хөрөнгийн элэгдлийн судалгаа сая.төг
Хүснэгт №6	Хөрөнгө оруулалтын судалгаа /сая.төг
Дүрслэл № 1	Системийн хэмжээнд 2016-2017 онд шинэ жил, байгууллагын ойн арга хэмжээнд үр ашиггүй зарцуулсан хөрөнгийн судалгаа: /сая.төг
Дүрслэл № 2	Системийн хэмжээнд 2016-2017 онд бусад баяр ёслолд /март 8, эрчим хүчний ажилтны өдрийн арга хэмжээ/ зарцуулсан хөрөнгийн судалгаа: /сая.төг/
Дүрслэл № 3	Системийн хэмжээнд 2016-2017 онд олгосон үр дүнгийн урамшуулал
Дүрслэл № 4	Төлөвлөгөөт хөрөнгө оруулалтын ажлуудын ХАА-нд мөрдсөн журам



Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

“АУЭХС” ТӨХК-ийн 2016-2017 оны үйл ажиллагааны үр дүнд аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- **Компани бүрэн хүчин чадлаар цахилгаан үйлдвэрлэх явцад хэрэглэгчдийн үнэ тарифыг одоогийн үнээс доогуур үнээр хүргэх боломж байгаа эсэх:**
- **Компани үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлж орлого, татаасыг зохих ёсоор зарцуулсан эсэх:**
- **Компанийн худалдан авалт, гүйцэтгэл үр дүнтэй байгаа эсэх:**

Аудитаар “АУЭХС” ТӨХК-ийн Говь-Алтай аймагт байрлах Толгой компани, “Тайшир-Гуулин УЦС” ХХК, “АУЭХС” ТӨХК-ийн Завхан аймаг дахь салбар, “Богдын голын УЦС” ХХК, “Тосонцэнгэл УЦС” ХХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой баримт материалуудыг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын шалгалтын журам болон гүйцэтгэлийн аудитын стандарт /АДБОУС 300, 3000, 3100/-ыг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ингэхдээ “АУЭХС” ТӨХК-тай холбоотой хууль, эрхийн актыг судлах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, тооллого хийх, төрөл бүрийн судалгаа, тайлан зэрэг баримт, мэдээлэлд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ “Тохижилт үйлчилгээний газар” болон болон Есөнбулаг сумын Төрийн сангаас лавлагаа судалгаа авч, хогны төлбөрийн орлогыг тулган баталгаажуулсан, мөн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг зураг төсөв, ТЭЗҮ-ийн дагуу хийгдсэн эсэхийг үзлээ.

Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

Үүнд:

- Эрчим хүчний тухай хууль
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
- Монгол улсын 2016, 2017 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Төсвийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль



- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн стандартыг хангуулж, нийцлийн аудитын багийн ахлах аудитор Д.Цэрэнханд ахалж, аудитор Х.Билэгбаяр, Г.Цэцэгмаа, М.Атарцэцэг нар 2018 оны 06 дугаар сарын 04-өөс эхлэн, 2018 оны 09 дүгээр сарын 15-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

“АУЭХС” ТӨХК нь Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 233 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдаж 9 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь 2017 онд 5 хэлтэс, 3 алба, хөдөө сумдын 44 нэгж, Завхан салбар, 3 охин компанийн бүтэцтэй 330 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж 2 аймгийн 21,448 хэрэглэгчдийг чанартай, найдвартай цахилгаан эрчим хүчээр ханган ажилласан байна. Систем компани дараах тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Үүнд:

1. Цахилгаан дамжуулах
2. Цахилгаан үйлдвэрлэх
3. Цахилгаан түгээх
4. Цахилгаанаар зохицуулалттай хангах
5. Тоолуур худалдах, засварлах, суурилуулах, тохируулах
6. Эрчим хүчний барилга, шугам сүлжээ барих, засварлах

Алсын хараа: Эдийн засгийн хувьд өөрөө өөрийгөө тэтгэдэг, найдвартай эх үүсвэр, оновчтой бүтэцтэй эрчим хүчний салбарт хөгжлөөр тэргүүлэгч компани болно.

Эрхэм зорилго: Говь-Алтай, Завхан аймгийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хосолмол эх үүсвэрээр тогтвортой хангах

Нийт орлогын 2017 оны батлагдсан төлөвлөгөө 102 хувьтай биелсэн боловч үйл ажиллагааны бус орлого 78.9 сая төгрөгөөр тасарч гүйцэтгэл 58 хувьтай биелсэн байна.

Тайлант онд 3,150.0 сая төгрөгийн татаас авахаар төлөвлөн гүйцэтгэлээр 100 хувь авчээ. Зардлын гүйцэтгэлийн тухайд батлагдсан төлөвлөгөөнөөс 1,037.1 сая төгрөгийн зардлыг хэмнэж ажилласан байна.

Компанийн эдийн засгийн үзүүлэлтийг гаргахад нийт авлага 28.7 сая төгрөгөөр, нийт өглөг 265.0 сая төгрөгөөр тус тус буурсан, борлуулж буй ЦЭХ-ний үнэ дунджаар 2.9 сая төгрөгөөр өсөж борлуулж буй ЦЭХ-ийн өртөг 5.7 сая төгрөгөөр буурчээ.

Компанийн нийт хөрөнгийн дүн оны эхэнд 104,640.3 сая төгрөг оны эцэст 103,916.6 сая төгрөг болж 723.7 сая төгрөгөөр буурчээ.

“АУЭХС” ТӨХК нь 2016 онд 2,534.7 сая төгрөг, 2017 онд 2,240.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Систем компанийн борлуулалтын орлого 2017 онд 7,101.6 сая төгрөгт хүрч өмнөх оноос 310.1 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Компанийн борлуулалтын орлого нэмэгдэхэд цахилгаан эрчим хүчний нэгж тарифыг ЭХЗХ-ны 2017 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор 3.58 төгрөгөөр нэмэгдүүлсэн үнийн өсөлт нөлөөлсөн байна.

**БҮЛЭГ 1: ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭН, ХЭРЭГЛЭГЧДЭД ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧИЙГ 11.3 ТӨГРӨГӨӨР ХЯМД БОРЛУУЛАХ БОЛОМЖТОЙ БАЙНА****Компаний зорилтот түвшинд нийт зардал, алдагдлыг өндөр төлөвлөсөн, энергийн мэдээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргаагүй байна**

“АУЭХС” ТӨХК-ийн 2016-2017 онд дэвшүүлсэн зорилтот түвшнийг ТУЗ-өөс баталж өгсөн байна. Батлагдсан зорилтот түвшнийг төлөвлөгөө, гүйцэтгэлтэй харьцуулан, бодит гүйцэтгэлийг давтан тооцоолоход:

- 1.1.1 Энергийн мэдээний хувьд: Нийт үйлдвэрлэсэн ЦЭХ-ийг 2016 онд 153.7 мянган квт цагаар илүү, 2017 онд 28.5 мянган квт цагаар дутуу, дотоод хэрэгцээнд зарцуулсан энергийг 2016 онд 86.0 мянган квт цагаар илүү, 2017 онд 49.3 мянган квт цагаар илүү, түгээсэн ЦЭХ-ийг 2016 онд 67.6 мянган квт цагаар илүү, 2017 онд 77.8 мянган квт цагаар дутуу мэдээлжээ.
- 1.1.2 Орлогын хувьд: Нийт орлогыг 2016 онд 9,689.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 9,873.5 сая төгрөг орж, 183.9 сая төгрөгөөр илүү буюу 1.8 хувиар давуулан биелүүлсэн, 2017 онд 10,135.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 10,358.4 сая төгрөг орж, 222.5 сая төгрөгөөр илүү буюу 2.2 хувиар давсан байна.
- 1.1.3 Зардлын хувьд: Нийт зардлыг 2016 онд 13,733.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 12,408.3 сая төгрөгийг зарцуулж, 1,324.7 сая төгрөгийг хэмнэсэн, 2017 онд 13,636.2 төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 12,599.1 сая төгрөгийн зарцуулж 1,037.1 сая төгрөгийг хэмнэжээ. Зардлыг хэмнэсэн боловч бодит бус хэмнэлт байна. Өөрөөр хэлбэл зардлын төлөвлөлтийг үндэслэлгүй өндөр төлөвлөсөнтэй холбоотой байна.
- 1.1.4 Алдагдлын хувьд: Нийт алдагдлыг 2016 онд 4,043.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,534.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, 2017 онд 3,500.0 сая төгрөгөөр төлөвлөж, 2,240.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Эндээс харахад алдагдлыг үндэслэлгүй өндөр төлөвлөсөн байна. Мөн алдагдалтай ажиллаж байгаа гол шалтгаан нь үндсэн хөрөнгийн элэгдэл өндөр, үр ашиггүй зардал их гаргасантай холбоотой байна.
- 1.1.5 Авлагын хувьд: Нийт авлагыг 2016 онд 350.0 сая төгрөгөөр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 135.5 сая төгрөгийн авлагатай, 2017 онд 350.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 106.8 сая төгрөгийн авлагатай ба гүйцэтгэлийг давтан тооцоход 107.0 сая төгрөг буюу 0.25 сая төгрөгийг зөрүүтэй мэдээлсэн байна.
- 1.1.6 Өглөгийн хувьд: Нийт өглөгийг 2016 онд 450.0 сая төгрөгөөр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 500.3 сая төгрөгийн өглөгтэй, аудитаар давтан тооцоолоход 500.7 сая төгрөг буюу 0.36 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн. 2017 онд 450.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 235.3 сая төгрөгийн өглөгтэй байна. */Дэлгэрэнгүй судалгааг хавсралт №1-ээс үзнэ үү/*

Зорилтот түвшний биелэлтээр энергийн мэдээ, авлага, өглөгийг зөрүүтэй мэдээлсэн нь “АУЭХС” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2012 оны 04 дүгээр сарын 25-ын өдрийн 05 дугаар тогтоол "Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай" 8.11.2¹ дахь заалтыг зөрчсөн байна.

¹ Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг хуульд заасан хугацаанд гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүнийг үнэн зөвийг хариуцах



1.2 Аудитад хамрагдсан ажилчдын 28.5 хувь нь ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагуудыг хангахгүй байна

1.2.1 “АУЭХС” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 4 дүгээр сарын 15-ний өдрийн 06 дугаар тушаалаар Толгой компанийн бүтцийг 136-н орон тоотойгоор, Завхан аймаг дахь салбарыг 99-н орон тоотойгоор, “Тайшир-Гуулин УЦС” ХХК-ийг 40-н орон тоотойгоор, “Тосонцэнгэл УЦС” ХХК-ийг 20-н орон тоотойгоор, “Богдын гол УЦС” ХХК-ийг 35-н орон тоотойгоор нийт 330-н орон тоотойгоор баталсан байна. Батлагдсан бүтэц орон тооны дагуу компаниуд тус бүрдээ ажлын байрны тодорхойлолтыг албан тушаал тус бүрээр боловсруулан баталж мөрджээ.

Системийн хэмжээнд нийт ажилчдын 58.3 хувь буюу үндсэн үйл ажиллагааг явуулдаг нарийн мэргэжил, мэргэшил шаардагдах 193-н ажилтны хувийн хэргийг сонгон авч, ажлын байрны тодорхойлолттой нийцэж байгаад үнэлэлт дүгнэлт өглөө.

1.2.2 Ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлага боловсрол, мэргэжил, мэргэшил, ажлын туршлага гэсэн 4-н үндсэн мэдээллийн дагуу үзэхэд дараах зөрчлүүд байна. Тухайлбал:

- **Боловсролын хувьд:** Судалгаанд хамрагдсан нийт 193-н ажилтнуудаас магистр зэрэгтэй 13-н ажилтан, бакалавр зэрэгтэй 81-н ажилтан, тусгай дунд боловсролтой 31-н ажилтан, бүрэн дунд боловсролтой 55-н ажилтан, бүрэн бус боловсролтой 13-н ажилтан байна. “АУЭХС ТӨХК”-ийн Толгой компанид 2 ажилтан, Завхан аймаг дахь салбарт 2 ажилтан, “Тосонцэнгэл УЦС” ХХК-д 1 ажилтан нийт 5-н ажилтан ажлын байрны тодорхойлолтод заасан боловсролын шаардлагыг хангахгүй байна. Энэ нь судалгаанд хамрагдсан нийт ажилтны 2.6 хувийг эзэлж байна.
- **Мэргэжлийн хувьд:** Эрчим хүчний салбар нь нарийн мэргэжил шаарддаг онцлогтой байгууллагын хувьд ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжлээс зөрүүтэй нийт 29-н ажилтан ажиллаж байгаа нь тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг дутагдах, үүний улмаас ажлыг чанаргүй хийх, цаашлаад хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдах, байгууллагын үндсэн зорилт хангагдахгүй байх эрсдэлийг бий болж байна. */Дэлгэрэнгүй судалгааг хавсралт №2-өөс үзнэ үү/*
- Гэсэн хэдий ч эрчим хүчний сургалт хөгжлийн цогцолборын нарийн мэргэжлийн сургалтад ажилчдаа хамруулж мэргэжлийн зэрэг олгосон байна.
- **Мэргэшлийн хувьд:** “АУЭХС” ТӨХК-ийн Толгой компанид 2 ажилтан, Завхан аймаг дахь салбарт 7 ажилтан, нийт 9-н ажилтан ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэшлийн шаардлагыг хангахгүй байна. Энэ нь судалгаанд хамрагдсан нийт ажилтны 4.6 хувийг эзэлж байна. */Дэлгэрэнгүй судалгааг хавсралт №3-аас үзнэ үү/*
- **Ажилласан жилийн хувьд:** Ажилд шинээр орсон ажилчдын ихэнх нь ажлын байрны тодорхойлолтод заасан ажилласан жилийн шаардлагыг хангахгүй байгаа нь харагдаж байна. Гэсэн ч аудит хийх хугацаагаар тасалбар болгож авч үзэхэд “АУЭХС” ТӨХК-ийн Толгой компанид 4 ажилтан, Завхан аймаг дахь Салбарт 4 ажилтан, “Тосонцэнгэл УЦС” ХХК-д 3 ажилтан, “Богдын гол УЦС” ХХК-д 1 ажилтан, нийт 12 ажилтан одоогийн байдлаар ажилласан жилийн шаардлагыг хангахгүй байна. */Дэлгэрэнгүй судалгааг хавсралт №4-өөс үзнэ үү/*

1.2.3 “АУЭХС” ТӨХК-ийн Толгой компани, “Тайшир Гуулин УЦС” ХХК, “Богдын голын УЦС” ХХК, “Тосонцэнгэл УЦС” ХХК-иуд нь ажлын байрны тодорхойлолтыг бүрэн боловсруулаагүй буюу тавигдах шаардлага болох мэргэжил мэргэшлийг дутуу тавьсан, чухал шаардлагатай заалтыг оруулж өгөөгүй зэрэг Төрийн албаны зөвлөлийн баталсан ажлын байрны тодорхойлолтыг загварын дагуу боловсруулаагүй байна. Завхан аймаг дахь салбарын хувьд ажлын байрны тодорхойлолтыг баталсан загварын дагуу гаргажээ.



1.3 Компани санхүүгийн хувьд хараат, ашигт ажиллагааны хувьд алдагдалтай ажилласан байна.

“АУЭХС” ТӨХК-ийн 2016 он, 2017 оны санхүүгийн тайланд Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар баталсан “Аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх аргачлалын дагуу чухал шаардлагатай болох шинжилгээнүүдийг хийхэд дараах байдалтай байна.

- **Балансын бүтцийн шинжилгээ:** Балансын бүтцийг авч үзвэл нийт хөрөнгө 103,916.6 сая төгрөгт хүрч, урьд оны мөн үетэй харьцуулахад **4 хувь** буюу 723.7 сая төгрөгөөр буурчээ. Нийт хөрөнгөөс эргэлтийн хөрөнгө 3.2 хувийг, эргэлтийн бус хөрөнгө 96.8 хувийг эзэлж байна. Эх үүсвэрийн хувьд өр төлбөр 42.1 хувь, эзний өмч 57.9 хувийг тус тус эзэлж өр төлбөрийн дүн өнгөрсөн оноос 267.3 сая төгрөгөөр, эзэмшигчдийн өмчийн дүн 456.4 сая төгрөгөөр буурсан байна./*Дэлгэрэнгүй шинжилгээг хавсралт №5-аас үзнэ үү*/
- **Төлбөрийн чадварын шинжилгээ:** “АУЭХС” ТӨХК-ийн Толгой компанийн хувьд мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нь 2016 онд БХӨТ-н 60.8 хувийг, 2017 онд 50.5 хувийг барагдуулах боломжтой байна. БХӨТ-ийг барагдуулах ойрын боломж буюу мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, авлагын дүн нь 2016 онд нийт БХӨТ-н 69.1 хувийг, 2017 онд 59 хувийг эзэлж байна. Энэ нь түргэн хөрвөх чадвар сайн байгааг илэрхийлж байна. “Тайшир Гуулин УЦС” ХХК-ийн хувьд мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нь 2016 онд нийт БХӨТ-н 3.2 хувийг, барагдуулах боломжтой байсан бөгөөд өр төлбөрийн дүн өндөр байсан байна. 2017 онд БХӨТ-ийн хэмжээ 0.08 сая төгрөг буюу мөнгөн хөрөнгөөр 100 хувь бүрэн барагдуулах боломжтой байна.
- **Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ:** Хараат байдлын коэффициентийн зохистой утга 1-2 хооронд “АУЭХС ТӨХК”-ийн Толгой компани, Завхан аймаг дахь салбар, “Тосонцэнгэл УЦС” ХХК, “Богдын голын УЦС” ХХК-иуд нь байгаа учир гаднын эх үүсвэрээс хараат бус байгааг илэрхийлж байна. Харин “Тайшир-Гуулин УЦС” ХХК-ийн хувьд – 44.3 байгаа нь гадны эх үүсвэрээс хараат байгааг харуулж байна. Учир санхүүгийн тайланд УЦС-ын барилга байгууламжийн өртөг 42,805.5 сая төгрөгийн урт хугацаатай зээл бүртгэлтэй байна. “Тайшир-Гуулин УЦС” ХХК-ыг эс тооцвол “АУЭХС” ТӨХК нь нийт дүнгээрээ 1.7 байгаа нь гадны үүсвэрийн оролцоо бага байгааг харуулж байна. Бие даалтын коэффициентийн зохистой утга 0.6-аас их бол санхүүгийн хувьд бие даасан гэж үзэх бөгөөд 2016, 2017 онд 0.58 байгаа нь санхүүгийн хувьд бие даах боломжгүй байгааг илэрхийлж байна.
- **Эргэцийн шинжилгээ:** “АУЭХС” ТӨХК-ийн авлага 5.4 хоногийн хугацаанд эргэн төлөгдөж байгаа нь авлагаа богино хугацаанд цуглуулж байгааг харуулж байна. Тус байгууллага сарын 25-ны өдрөөр хэрэглэгчдэд цахилгааныг хязгаарлаж хэвшснээр цахилгааны мөнгөө төлөхгүй байх эрсдэл буурч, авлагын хугацааг богиносгох гол хөшүүрэг болжээ.
- **Ашигт ажиллагааны шинжилгээ:** Ашигт ажиллагааны шинжилгээнүүдийг 2016, 2017 оноор хийж үзэхэд компани тус бүр алдагдалтай ажилласныг харуулж байна. Зөвхөн “Тосонцэнгэл УЦС” ХХК нь 2016 онд ашигтай ажилласан байна. /*Дэлгэрэнгүй шинжилгээг хавсралт №6-аас үзнэ үү*/

1.4 Хүний нөөц, техникийн нөөцийг уялдуулан тооцсон хүчин чадлаар ажиллавал ЦЭХ-ний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх боломжтой байна

1.4.1 Хүний нөөц, түүнтэй холбоотой санхүүгийн нөөцийн талаар: Тус систем компанийн хувьд хүний нөөцийн хэрэгцээ бүрэн хангагдсан, “АУЭХС” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2017 оны 4 сарын 6-ний өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан орон тооноос илүү хүн ажиллуулан, Завхан аймаг дахь салбар, “Тайшир-Гуулин УЦС” ХХК, “Тосонцэнгэл УЦС” ХХК-иуд цалингийн зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна. Тухайлбал:

- “АУЭХС” ТӨХК-ийн Толгой компани нь 5 орон тоо дутуу, 3 орон тоо илүү ажиллуулан 19.1 сая төгрөг,
- Завхан аймаг дахь салбар 1 орон тоо дутуу, 2 орон тоо илүү ажиллуулан 12.8 сая төгрөг
- “Тосонцэнгэл УЦС” ХХК 2 орон тоо илүү ажиллуулан 16.5 сая төгрөг

Хүснэгт № 1: Хүний нөөц, түүнтэй холбоотой санхүүгийн нөөцийн судалгаа

Д/Д	Байгууллагын нэр	Батлагдсан орон тоо гүйцэтгэл /2017 он/		Цалингийн сан төлөвлөгөө гүйцэтгэл /2017 он/		Орон тоо болон цалин зардал зөрүү /2017 он/	
		ТУЗ-аар баталсан орон тоо	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Орон тоо илүү-, дутуу	Цалингийн хэмнэлт, хэтрэлт-
1	“АУЭХС” ТӨХК	136	134	1,428.97	1,420.0	2	8.97
2	Завхан салбар	100	101	970.75	995.14	-1	-24.39
3	Богдын гол УЦС ХХК	35	35	396.04	385.5	0	10.54
4	Тайшир-Гуулин УЦС ХХК	40	40	443.5	450.3	0	-6.8
5	Тосонцэнгэл УЦС ХХК	20	22	225.3	249.5	-2	-24.2
Дүн		331	332	3,464.56	3,500.44	-1	-35.88

1.4.2 Мөн ТУЗ-ын 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “АУЭХС” ТӨХК-ийн Толгой компанийн ажиллагсад 70.3 сая төгрөгийг, Завхан аймаг дахь салбарт 46.0 сая төгрөг, “Богдын голын УЦС” ХХК-д 17.8 сая төгрөг, “Тайшир-Гуулин УЦС” ХХК-д 21.7 сая төгрөг, “Тосонцэнгэл УЦС” ХХК-д 9.9 сая төгрөгийг нийт 165.8 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг давхардуулан журмаас илүү тооцож олгосон нь санхүүгийн нөөцийг үрэлгэн, хэмнэлтгүй зарцуулсныг харуулж байна.

1.4.3 Техник тоног төхөөрөмж, түүнтэй холбоотой энергийн талаар: Тус систем компани нь 2017 онд 38,147.21 мян кВт эрчим хүч үйлдвэрлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 39,677.44 мян кВт эрчим хүч үйлдвэрлэж, 1,906.88 мян кВт илүү үйлдвэрлэсэн байна. Хэрэв бүрэн хүчин чадлаараа ажиллавал 48,707.86 мян кВт эрчим хүч үйлдвэрлэж, 9,030.4 мян кВт илүү үйлдвэрлэх боломж байна.

Хүснэгт №2: Энергийн мэдээ хүчин чадлын судалгаа

мян.квт.ц

№	Үзүүлэлт	Өмнөх он /2016 он/	Цахилгаан энергийн тооцоо /2017 он/		Аудитаар тооцсон /ЦЭХ үйлдвэрлэх хүчин чадал/	2017 оны гүйцэтгэлтэй харьцуулахад / илүү үйлдвэрлэх боломж/	Тайлбар:
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл			
Нийт		68,829.2	66,348.0	70,137.16	78,964.99	-8,827.83	
1	ББЭХС ТӨХК/мян кВт.ц/	4,155.82	3,283.29	3,268.33	3,268.33	0.0	1 кВт ц 94.57 төг худалдан авсан
2	ЦДҮС ХК /мян кВт.ц/	23,089.06	24,917.5	27,191.39	26,988.8	202.59	1 кВт ц 50 төг худалдан авсан



3	Үйлдвэрлэсэн ЦЭХ /мян кВт.ц/	41,584.32	38,147.21	39,677.44	48,707.86	-9,030.42	кВт ц 66.45 төг үйлдвэрлэх
---	------------------------------	-----------	-----------	-----------	-----------	-----------	----------------------------

1.4.4. “ББЭХС” ТӨХК, “ЦДҮС” ХК-иудаас худалдан авч байгаа энергийн хэмжээ нь хэрэглээ, үйлдвэрлэлтээс хамааран жил бүр харилцан адилгүй байна. Учир нь “Тайшир-Гуулин УЦС”, “Гуулин УЦС”, “Богдын голын УЦС”, “Тосонцэнгэл УЦС”, “Галуутайн УЦС”, “Хүнгүйн УЦС”-ууд нь усны түвшнээс хамаарч, үйлдвэрлэлт өөр өөр байна. *Дэлгэрэнгүй судалгааг хавсралт №7-оос үзнэ үү*

1.5 Хэрэглэгчдэд ЦЭХ-ийг 11.3 төгрөг буюу одоо борлуулж байгаа үнээс 12%-иар бууруулах боломжтой байна

1.5.1 Аудитаар үйл ажиллагааны бусад орлогыг нэмэгдүүлэн /хүү, телевизийн хураамж, хогны хураамж/, тэвчиж болох зардал буюу үр ашиггүй зардал /ой, тэмцээн уралдаанд зарцуулсан зардал, орон тоо илүү ажилласнаас цалингийн зардал/- ыг 2017 онд 332.7 сая төгрөгөөр хэмнэснээр алдагдлыг 6.1 хувиар, хэрэглэгчдэд борлуулж байгаа ЦЭХ-ний дундаж үнийг 11.3 төгрөг буюу 12 хувиар, ЦЭХ-ийн өртгийг 24.3 төгрөг буюу 13.5 хувиар, нийт алдагдлыг 13 төгрөг буюу 16.5 хувиар бууруулах боломжтой байна. *Дэлгэрэнгүй судалгааг хавсралт №8-аас үзнэ үү*

Үйл ажиллагааны зардлаас үр ашиггүй зардлыг хасаж, тооцсон хүчин чадлаараа ажиллавал үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг, борлуулсан бүтээгдэхүүний өртөг, хэрэглэгчдэд борлуулж буй ЦЭХ-ний үнэ буурах боломжтой байна.

1.6 Дотоод хяналт аудитын алба нь 2016 оныг эс тооцвол, техникийн болон хөдөлмөр хамгааллын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.

1.6.1 “АУЭХС” ТӨХК-ийн Дотоод хяналтын алба нь 2016-2017 онуудад Дотоод хяналтын албаны дарга, ХАБЭА инженер, Техник хяналтын инженер, Аудитор зэрэг 4 орон тоотой үйл ажиллаж байна. Үйл ажиллагаанд 3 чиглэлээр хяналтыг хэрэгжүүлж, шийдвэр гаргасан байна. Үүнд:

- Дотоод хяналтын албаны даргад хууль эрх зүйн чиглэлээр 2016 онд хийгдсэн шалгалтын материалыг ажил хүлээлцэх үед хүлээлгэн өгөөгүй, тус онд өгсөн шийдвэр зөвлөмжийн материал байхгүй гэсэн үндэслэлээр аудитад хамрагдсангүй, харин 2017 онд тухай бүр хууль эрх зүйн чиглэлээр 154 удаагийн албан даалгавар өгч, 3 удаагийн төлөвлөгөөт шалгалт хийж 13 заалттай зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллажээ.
- ХАБЭА инженерийн тухайд 2016-2017 онуудад тухай бүрд 1044 удаагийн албан даалгавар, 5 удаагийн төлөвлөгөөт шалгалтаар 16 заалттай зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцож ажиллажээ.
- Техник хяналтын инженерийн тухайд 2016-2017 онуудад тухай бүрд 338 удаагийн албан даалгавар, 4 удаагийн төлөвлөгөөт шалгалтаар 9 заалттай зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцож ажиллажээ.

Үйл ажиллагаатай холбоотой өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласнаар ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлын орчин хангагдан, ажил үүргийг хугацаанд чанартай гүйцэтгэх болсон байна.

**БҮЛЭГ 2: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭЭГҮЙ, ХӨРӨНГИЙГ ҮР АШИГГҮЙ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА.****2.1 Компани үйл ажиллагааны бус орлогыг нэмэгдүүлэх боломжтой, санхүүгийн тайланд орлогыг зөрүүтэй тайлагнасан байна.**

АУЭХС” ТӨХК нь 2016 онд борлуулалтын орлогоос 6,791.5 сая төгрөг, хүүгийн орлогоос 6.8 сая төгрөг, үйл ажиллагааны бусад орлогоос (татаас, хог, телевизийн хураамж, алданги, техникийн нөхцөл, тоолуурын үнэ, тендерийн баримт бичгийн үнэ холболтын хураамж г.м) 2,438.2 сая төгрөг нийт 9,236.6 сая төгрөгийн орлого, 2017 онд борлуулалтын орлогоос 7,101.6 сая төгрөг, хүүгийн орлогоос 20.7 сая төгрөг, бусад орлогоос 2,461.0 сая төгрөг нийт 9,584.1 сая төгрөгийн орлого тус тус орсноор тайлагнажээ.

Аудитаар орлогын тулгалтыг давтан тооцоход орлого дутуу тайлагнасан, дутуу төвлөрүүлсэн, орлого олох боломжийг алдсан дараах зөрчлүүд байна. Тухайлбал:

2.1.1 “АУЭХС” ТӨХК-ийн орлого үр дүнгийн тайланд 2016 оны борлуулалтын орлогыг 60.6 сая төгрөгөөр дутуу, 2016-2017 оны үйл ажиллагааны бусад орлогыг 105.0 сая төгрөгөөр тус тус дутуу буюу орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнаагүй. Үүнд:

- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн 95.6 сая төгрөг
- Цахилгааны эх үүсвэртэй болгох ажлын 3.1 сая төгрөг
- Алдангийн орлого 5.7 сая төгрөг
- Бусад орлого 0.6 сая төгрөг

2.1.2 Завхан аймаг дахь салбарын 2016-2017 оны орлого үр дүнгийн тайланд телевизийн үйлчилгээний хураамжийн орлого 42.9 сая төгрөгийг үйл ажиллагааны бусад орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнаагүй, зарцуулсан.

2.1.3 Тус систем компанийн мөнгөн гүйлгээний тайланд 64.6 сая төгрөгийг дутуу, 169.8 сая төгрөгийг илүү тайлагнасан, 701.2 сая төгрөгийг зөрүүтэй тайлагнасан байна. Үүнд:

- “АУЭХС” ТӨХК нь 2016-2017 онд НД-аас шилжүүлсэн листийн орлогыг 1.9 сая төгрөгөөр дутуу, бусад орлогыг 35.0 сая төгрөгөөр илүү
- Завхан аймаг дахь салбар нь 2016-2017 онд хүүгийн орлогыг 6.7 сая төгрөгөөр дутуу, НД-аас шилжүүлсэн листийн орлогыг 11.3 сая төгрөгөөр дутуу, бусад орлогыг 133.3 сая төгрөгөөр илүү
- “Богдын гол УЦС” ХХК нь 2017 онд ББҮҮО-ыг 20.1 сая төгрөгөөр дутуу, бусад орлогыг 1.5 сая төгрөгөөр илүү
- “Тайшир-Гуулин УЦС” ХХК нь 2016 онд ББҮҮО-ыг 20.0 сая төгрөгөөр дутуу, 2016-2017 онд НД-аас шилжүүлсэн листийн орлогыг 4.2 сая төгрөгөөр дутуу, 2017 онд бусад орлогыг 10.4 сая төгрөгөөр дутуу
- “Тосонцэнгэл” УЦС нь 2016 оны борлуулалтын орлого 286.6 сая төгрөг, 2017 оны борлуулалтын орлого 414.6 сая төгрөгийг тус тус бусад орлогоор зөрүүтэй тайлагнасан.

Санхүүгийн тайланг УСНББОУС-1, УСНББОУС-23, НББОУС-7, НБББББ-ын 7 дугаар бүлэг мөнгөн хөрөнгийн бүртгэлийн бодлого,горим, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 3 дугаар бүлэг "Орлогын дэлгэрэнгүй тайлан"-г бэлтгэх зааврын дагуу бэлтгээгүй байна.

2.1.4 Систем компанийн хувьд үйл ажиллагааны бусад орлогыг нэмэгдүүлэх дараах боломжууд байна. Үүнд:



- Есөнбулаг сум, Тохижилт үйлчилгээний газартай хамтран байгуулсан гэрээний 4.2.2² дахь заалтыг үндэслэн 2014-2017 оны хогны төлбөрийг орлогыг тооцож үзэхэд 55.1 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх /Дэлгэрэнгүй судалгааг хавсралт №9-өөс үзнэ үү/
- МҮОНТ-тэй байгуулсан гэрээний 4.2.4³, 4.2.5⁴ дахь заалтуудыг үндэслэн телевизийн хураамжийн тооцоог хийж үзэхэд ГАА-ын хувьд 27.4 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн ба энэ орлогын 20% буюу 5.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, Завхан аймгийн хувьд 2.6 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн ба орлогын 25% буюу 0.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх /Дэлгэрэнгүй судалгааг хавсралт №10-аас үзнэ үү/
- “АУЭХС” ТӨХК-ийн системийн хэмжээнд 2016 онд 6.6 сая төгрөгийн хүүгийн орлого орсон бөгөөд 2017 онд 3 дахин өсөж, 22.6 сая төгрөг орсон, банкттай байгуулсан харилцах дансны гэрээ байгаа эсэх нь тодорхой бус аудитад “АУЭХС” ТӨХК-ийн харилцах дансны гэрээ хамрагдаагүй, зарим гэрээг 0 хувийн хүүтэйгээр байгуулсан нь арилжааны банканд давуу байдлыг бий болгосон гэрээ болжээ.

2.1.5 Хогны төлбөрийг орлогыг төвлөрүүлэх талаар Тохижилт үйлчилгээний газар, Есөнбулаг сумтай хамтран байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний 2.3.5 дахь заалтын дагуу 2016 онд 0.57 сая төгрөг, 2017 онд 0.1 сая төгрөгийн нийт 0.674 сая төгрөгийн алдангийг ЕБ-ын ОНӨО-д төвлөрүүлээгүй байна.

2.2 Албан татвар, хураамжийг улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна

2.2.1 Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх цалингийн ашиг, ААНОАТ, ХХОАТ, НӨАТ, Үл хөдлөх хөрөнгийн албан татвар, АТӨЯХ-ийн албан татвар, ус ашигласны төлбөр, газрын татварын тайлангаар 2016 онд нийт 564.3 сая төгрөгийн ногдуулалт хийж, 559.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн, 2017 онд 1,374.3 сая төгрөгийн ногдуулалт хийж, 1,448.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт № 3: Татварын тайлангийн тулгалт /сая.төг/

Утга	Тайлангаар	2016 он	2017 он
Татварын тайлангаар	Эхний үлдэгдэл	20.84	85.31
	Татвар ноогдуулсан дүн	564.27	1,371.98
	Шилжүүлсэн мөнгөн дүн	559.36	1,450.00
	Эцсийн үлдэгдэл	25.75	7.29
Аудитаар	Эхний үлдэгдэл	20.84	85.38
	Татвар ноогдуулсан дүн	564.33	1,374.27
	Шилжүүлсэн мөнгөн дүн	559.62	1,448.02
	Эцсийн үлдэгдэл	25.55	11.63
Зөрүү	Эхний үлдэгдэл	-	(0.08)
	Татвар ноогдуулсан дүн	(0.05)	(2.29)
	Шилжүүлсэн мөнгөн дүн	(0.12)	1.98
	Эцсийн үлдэгдэл	0.07	(4.34)

Аудитаар татварын тайланд 2016 онд ногдуулалтыг 0.05 сая төгрөгөөр дутуу, төлөлтийг 0.12 сая төгрөгөөр дутуу, 2017 онд ногдуулалтыг 2.29 сая төгрөгөөр дутуу, төлөлтийг 1.98 сая

² Гүйцэтгэгч өөрийн програмд бүртгэгсэн нийт айл өрх, ААНБ-ын хог хаягдал гаргасны төлбөр буюу хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Хог хаягдлын тухай хуулийн дагуу Сумын ИТХТ-ын 2013 оны 04 тогтоолоор баталсан төлбөрийг сар бүр хураан авч төвлөрүүлэх

³ Цахилгаан эрчим хүч хэрэглэгч өрхийн тооны өсөлттэй ижил харьцаагаар хураамжийн орлогыг нэмэгдүүлэх

⁴ Гүйцэтгэгчийн удирдлага, удирдах дээд байгууллага гэрээ байгуулснаас хойш өөрчлөгдсөн эсэхээс үл шалтгаалан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх

⁵ Гүйцэтгэгч тал дараа сарын 10-ны дотор хог хаягдал гаргасны төлбөр буюу хог хаягдлын үйлчилгээний төлбөрийг шилжүүлээгүй тохиолдолд хоног тутам 0.1%-ийн алданги төлнө



төгрөгөөр илүү төлснөөр тайлангийн эцсийн үлдэгдлийг 4.34 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн буюу төлөөгүй байна. /Дэлгэрэнгүй судалгааг хавсралт №11, 12-оос үзнэ үү/

2.3 Хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгасан боловч, ТУЗ-ын тогтоол шийдвэргүйгээр 4.5 сая төгрөгийн хөрөнгөөр охин компаниудыг шагнасан байна.

2.3.1 “АУЭХС” ТӨХК нь системийн хэмжээнд 2016-2017 онд өөрийн хөрөнгөөр 1,208.9 сая төгрөгийг, Төрийн өмчийн хороо, ТУЗ-ын шийдвэрийн дагуу 9,612.7 сая төгрөгийн хөрөнгийг компани хоорондын тооцоогоор балансаас баланст шилжүүлж, 128.9 сая төгрөгийн хөрөнгийг капиталжуулж, 58.1 сая төгрөгийг данс хооронд шилжүүлэн бүртгэж, нийт 11,008.6 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн ба хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байна.

Хүснэгт №4: Нэмэгдсэн үндсэн хөрөнгийн судалгаа /сая.төг/

д/д	Хөрөнгийн эх үүсвэр	АУЭХС	Тайшир - Гуулин	Завхан салбар	Богдын Гол	Тосон цэнгэл	Нийт дүн
1	Өөрийн хөрөнгөөр	346.8	524.6	280.8	31.2	25.5	1,208.9
2	Балансаас баланст	7,456.5	24.7	230.1	1703.4	198	9,612.7
3	Хөр/оруулалт болон ТЗБАХ-аар капиталжуулсан	128.9	0	0	0.0	0	128.9
4	Данс хооронд шилжүүлсэн	58.1					58.1
	НИЙТ ДҮН	7,990.3	549.3	510.9	1,734.6	223.5	11,008.6

2.3.2 Аудит хийх явцад гүйцэтгэх захирлын 2018 оны А/127 тоот тушаалаар “АУЭХС ТӨХК”-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 4.5 сая төгрөгийн 3ш нөүтбүүкээр салбар болон охин компаниудыг шагнасан, мөн тооллогоор Истана машиныг бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25.1⁶ дахь заалт, 16.1.1⁷ дахь заалт, “АУЭХС ТӨХК”-ий хувьцаа эзэмшигчдийн хурлын 2012 оны 05 дугаар тогтоол "Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай" -ын 8.11.10⁸ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

2.4 Үр дүнгийн урамшуулалд 580.4 сая төгрөгийг давхардуулан олгосон, ой, баяр ёслолын арга хэмжээнд 91.0 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Системийн хэмжээнд 2016 онд ББҮҮО 10,008.9 сая төгрөг, НД-аас 10.3 сая төгрөг, НӨАТ-ийн буцаан олголтоор 211.0 сая төгрөг, Татаас санхүүжилтийн орлого 1,000.0 сая төгрөг, бусад мөнгөн орлого 3,247.0 сая төгрөг, хүүгийн орлого 6.6 сая төгрөг, нийт 14,848.4 сая төгрөгийн мөнгөн орлого орж, 13,803.8 сая төгрөгийг зарцуулжээ. 2017 онд ББҮҮО 10,942.9 сая төгрөг, НД-аас 32.3 сая төгрөг, НӨАТ-ийн буцаан олголтоор 211.0 сая төгрөг, Татаас санхүүжилтийн орлого 3,149.9 сая төгрөг, бусад мөнгөн орлого 1,788.0 сая төгрөг, үндсэн хөрөнгө борлуулсны орлого 0.95 сая төгрөг, хүүгийн орлого 22.6 сая төгрөг нийт 15,936.8 сая төгрөгийн мөнгөн орлого орж, 16,040.5 сая төгрөгийг зарцуулжээ.

2.4.1 Системийн хэмжээнд 2016-2017 оны анхан шатны баримтын тулгалтаар зарцуулалттай холбоотой дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Үндсэн цалинг, амралтын цалин давхардуулан олгосон – 4.5 сая төгрөг
- Цалин, томилолтын зардлыг илүү, дутуу олгосон -1.5 сая төгрөг

⁶ Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ 7 өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах

⁸ Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах шилжүүлэх, үндсэн хөрөнгийн асуудлыг ТУЗ-ийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх

- Ажиллагсад олгосон цалингийн урамшууллаас НДШ суутгаагүй, төлөөгүй – 12.1 сая төгрөг
- Нэр бүхий НӨАТ төлөгчдөөс худалдан авсан бараа материалын 10 хувийг тайлагнаагүй - 278.6 сая төгрөг
- Хувь хүнээс бараа материал худалдан авсан бөгөөд татвар суутгаагүй шилжүүлсэн -3.0 сая төгрөг
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад гүйлгээ хийсэн-16.1 сая төгрөг
- Өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, цалингийн урьдчилгааг томилолтын зардалд тайлагнасан -169.1 сая төгрөг
- Жолоочийн тооцооны хуудсыг хянахад шатахууныг нормоос илүү зарцуулсан-2.8 сая төгрөг
- Жолоочийн шатахууны замын хуудас бичээгүй, тооцоо бодоогүй ажлын хариуцлага алдсан- 35.8 сая төгрөг
- Татварын хэлтэст тайлагнасан тайлангууд зөрүүтэй -7.4 сая төгрөг
- Тооллогоор бараа материал ,хөрөнгө дутагдсан- 0.8 сая төгрөг
- Ажиллагсад үндсэн хөрөнгийг картлуулж өгөөгүй- 31.8 сая төгрөг
- Баяр ёслол, байгууллагын ой, тэмцээн уралдаанд үр ашиггүй зарцуулсан- 63.5 сая төгрөг
- УИХ-ын тогтоолыг зөрчин, 2016-2017 онд 27.4 сая төгрөгийг шинэ жил, ойн арга хэмжээнд үр ашиггүй зарцуулсан
- Ажиллагсад "сарын үр дүнгийн урамшуулал"-аас гадна 2016 онд 221.9 сая төгрөг, 2017 онд 358.5 сая төгрөг нийт 580.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон

Дүрслэл № 1: Системийн хэмжээнд 2016-2017 онд шинэ жил, санхүүчдийн баярын арга хэмжээнд үр ашиггүй зарцуулсан хөрөнгийн судалгаа: /сая.төг/




Тухайн систем компанийн хувьд шинэ жил, байгууллагын ойн арга хэмжээнд нийт 27.4 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1⁹ дахь заалт, МУ-ын Их Хурлын 2016 ны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 47 дугаар тогтоолын в.5¹⁰ дахь заалт, Хамтын гэрээний заалтуудыг тус тус зөрчсөн байна.

⁹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

¹⁰ төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх

Дүрслэл № 2: Системийн хэмжээнд 2016-2017 онд бусад баяр ёслолд /март 8, эрчим хүчний ажилтны өдөр, ойн араг хэмжээнд зарцуулсан хөрөнгийн судалгаа: /сая.төг/



Бусад баяр ёслолд /март 8, эрчим хүчний ажилтны өдрийн арга хэмжээ/ нийт 63.6 сая төгрөгийг зарцуулжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1¹¹ дахь заалт МУ-ын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 69 дугаар тогтоолын 4.3¹² дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. /Дэлгэрэнгүй судалгааг хавсралт №13-оос үзнэ үү/

2.4.2 ТУЗ-аас 2014 онд баталсан “сарын үр дүнгийн урамшуулал олгох”-ын журмаас гадна 2016 онд 221.9 сая төгрөг, 2017 онд 358.5 сая төгрөг нийт 580.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1¹³ дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 08 сарын 17-ны өдрийн 41 дүгээр тэмдэглэлд “Улсын төсвийн орлогын төлөвлөгөө тасарч, төсвийн зардлын эх үүсвэр хүрэлцэхгүй байгаа тул төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж, удирдлагын цалин хөлс, их хэмжээний шагнал, урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж олгохыг зогсоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Дүрслэл № 3: Системийн хэмжээнд 2016-2017 онд давхардуулан олгосон үр дүнгийн урамшуулал



2.4.3 ТУЗ-өөс баталсан орон тооноос “АУЭХС” ТӨХК нь 3 орон тоогоор, “Тосонцэнгэл УЦС” ХХК нь 2 орон тоогоор, Завхан аймаг дахь салбар нь 2 орон тоогоор нийт 7 орон тоо илүү ажиллуулан, 48.4 сая төгрөгийг илүү зарцуулсан байна. /Дэлгэрэнгүй судалгааг хавсралт №14-оос үзнэ үү/

2.4.4 Эд хариуцагчийн тухайд үндсэн хөрөнгө, бараа материал хүлээн авсан баримтгүй, тооллогоор хөрөнгө дутагдсан, илүүдсэн, нягтлан бодогчтой тооцоо нийлж тулган баталгаажуулалт хийгээгүй, нярвын тайлан зөрүүтэй, агуулахын бүртгэлийг тухай бүр хөтлөөгүй байна. Энэ нь эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийг хэрэгжүүлж ажиллахгүй, ажлын хариуцлага сул байгааг харуулж байна.

¹¹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

¹² төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн зардлыг багасгах, тэдгээрт ажиллагсдын тоог бууруулан 2012 оны түвшинд хүргэх

¹³ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах



2.5 Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг журмын дагуу тооцсон байна.

Системийн хэмжээнд 2016 оны 12 сарын 31-ны байдлаар 127,153.3 сая төгрөгийн балансын үнэтэй 958 нэр төрлийн үндсэн хөрөнгөнөөс тайлант онд 3,141.9 сая төгрөгийн хөрөнгийн элэгдэл байгуулсан, 2017 оны 12 сарын 31-ны байдлаар 934 нэр төрлийн 154,940.3 сая төгрөгийн балансын үнэтэй үндсэн хөрөнгөнөөс 3,283.4 сая төгрөгийн хөрөнгийн элэгдэл байгуулсан байна. Аудитаар давтан тооцоолоход зөрүү гараагүй.

Тус компаниуд нь үндсэн хөрөнгийн элэгдлийг ЭХЗХ-2015 оны 3 дугаар сарын 26-ны 86 тоот тогтоол, НББОУС болон Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаал, НБББББ-т заасны дагуу шулуун шугамын аргаар байгуулжээ.

Хүснэгт № 5: Үндсэн хөрөнгийн элэгдлийн судалгаа

Байгууллага	2016 он /сая.төг/					2017 /сая.төг/				
	тоо	Балансын үнэ	Тайлант онд байгуулсан элэгдэл	Аудитаар давтан тооцоолсон	Зөрүү	тоо	Балансын үнэ	Тайлант онд байгуулсан элэгдэл	Аудитаар давтан тооцоолсон	Зөрүү
1 АУЭХС	482	40,357.65	1,637.5	1,637.5	(0.00)	482	66,016.01	1,707.95	1,707.95	(0.00)
2 Завхан салбар	182	27,938.26	686.4	686.4	(0.00)	174	28,044.46	681.96	681.96	0.00
3 "Тайшир гуулин" УЦС	156	46,606.75	616.96	616.96	(0.00)	145	46,929.35	616.28	616.28	(0.00)
4 Тосон цэнгэл	58	2,583.02	38.8	38.8	0.00	52	2,634.99	38.91	38.91	0.00
5 "Богдын гол" УЦС	80	9,667.73	162.0	162.0	0.00	81	11,315.47	238.31	238.31	-
Нийт дүн	958	127,153.35	3,141.9	3,141.9	(0.00)	934	154,940.28	3,283.4	3,283.4	0

ЭХЗХ-ны 2015 оны 3 дугаар сарын 26-ны 86 тоот тогтоолын 3.1¹⁴, 3.3в¹⁵-д заасны дагуу системийн хэмжээнд нөөцөд байгаа шинэ хөрөнгө, эвдэрч ашиглах боломжгүй болсон хөрөнгө, ашиглах хугацаа дуусаж ашиглах боломжгүй актанд гарсан хөрөнгийг дуудлага худалдаанд оруулсан боловч санал ирээгүй зэрэг нийт 34 нэр төрлийн 3.613,6 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгөнд элэгдэл байгуулаагүй байна.

2.6 Санхүүгийн үйл ажиллагаа, зарцуулалтанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөө байхгүй, санхүүгийн чиглэлээр хийгдсэн 2016 оны шалгалтын материалыг “ажил хүлээлцэх үед хүлээлгэн өгөөгүй тус онд өгсөн шийдвэр зөвлөмжийн материал байхгүй” гэсэн шалтгааны улмаас аудитад хамруулаагүй.

Харин 2017 онд 1 удаа хяналт шалгалт хийж 5 заалттай зөвлөмж өгсөн байна.

Аудитаар илэрч байгаа зөрчлөөс үзэхэд санхүүгийн үйл ажиллагаанд нэр төдий хяналт шалгалт хийсэн, илт байгаа зөрчлийг илрүүлээгүй, хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй болох нь харагдаж байна. Энэ нь МУЗГ-ын 2015 оны 483-р тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Компанийн дотоод журмын 11.4¹⁶ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллахгүй байгааг харуулж байна

¹⁴ үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үе буюу түүнийг үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангасан үеэс эхлэн элэгдэл тооцно. Үйлдвэрлэл явуулаагүй үед элэгдлийн зардал тэг байж болно

¹⁵ Түр ашиглаагүй буюу нөөцөнд байгаа үндсэн хөрөнгөд элэгдэл тооцохгүй

¹⁶ Дотоод хяналтын алба нь дараах чиглэлүүдээр хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хууль дүрэм, журмыг мөрдүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд 11.4.6 дахь заалт /Санхүүгийн үйл ажиллагаа өмч хөрөнгийн бүртгэл тооцоо захиран зарцуулалт, ашиглалт хадгалалт хамгаалалт/

**БҮЛЭГ 3: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛУУДЫН 37 ХУВЬД СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ХИЙГЭЭГҮЙ. 2 АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ ДУТУУ БАЙНА.****3.1 Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлууд зайлшгүй шаардлагатай байсан хэдий ч төлөвлөгөөнд тусгагдаагүй 262.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.**

3.1.1 Систем компанийн 2016-2017 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг ТУЗ-ын тогтоолтой тулган баталгаажуулахад, төлөвлөгөөнд тусгагдаагүй 10 хөрөнгө оруулалтын ажлыг 262.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр санхүүжүүлжээ. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 46.1.4¹⁷ дэх заалтыг зөрчсөн байна.

Хүснэгт № 6: Хөрөнгө оруулалтын судалгаа


Огноо	Төлөвлөгөөт ХА		Төлөвлөгдөөгүй ХА	
	тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн
2016	8	338.2	5	103.9
2017	27	763.3	5	158.5
дүн	35	1,101.5	10	262.4

3.2 Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлын 37 хувьд, төлөвлөгдөөгүй хөрөнгө оруулалтын ажлын 65 хувьд худалдан авалтын сонгон шалгаруулалт хийгээгүй байна.

3.2.1 Тус систем компани нь 2017 онд төлөвлөгөөт 283.0 сая төгрөгийн 5 хөрөнгө оруулалтын ажил дээр худалдан авах ажиллагаа зарлаагүй шууд гэрээ байгуулжээ. Тухайлбал:

- Жаргалан ,Баян-Уул 15 кВ-ын ЦДАШ д холгогдож тасарсан 8км АС 50 маркны утас шинээр солих -16.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй
- Тайшир дэд станцын Улиастай 110 кВын ЦДАШ элегаз таслуур суурилуулах-90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй
- Трансформаторын засварын цехийг иж бүрнээр байгуулж ашиглалтад оруулах, Өндөр хүчдэлийн лабораторитой болох-30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй
- Улиастай 110 кВ-ын дэд станцын өргөтгөлийн ажлын тоног төхөөрөмж засварын ажлын зардал /тодотголоор/-135.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй
- Р-635 маркны дизелийн инжектор, порсункууд- 12.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй

Дүрслэл №4: Төлөвлөгөөт хөрөнгө оруулалтын ажлуудын ХАА-нд мөрдсөн журам



3.2.2 ТУЗ-аас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 2016 оны 5 ажил, 2017 оны 1 ажил, нийт 169.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ажилд худалдан авах ажиллагаа зарлаагүй гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 8.2¹⁸ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд:

¹⁷ худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах

¹⁸ Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.



- Хөдөлмөр хамгааллын хувцас нийлүүлэх- Хос Аз ХХК-тай 26.0 сая төгрөгийн, Өнөрбаян хайрхан ХХК-тай 30.9 сая төгрөгийн гэрээг шууд байгуулан, гүйцэтгэлийг харгалзан санхүүжүүлээгүй, 100% урьдчилж шилжүүлсэн.
- Компьютер принтер нийлүүлэх – Иргэн Баянбаатартай гэрээ байгуулалгүйгээр 31.0 сая төгрөгийг 100% урьдчилж шилжүүлсэн
- Сэлбэг хэрэгсэл худалдан авах – Сидан ХХК-тай гэрээ байгуулалгүйгээр 24.8 сая төгрөгийг 3 хувааж шилжүүлсэн.
- Ажлын гутал нийлүүлэх - Арвайн цалгиа ХХК-тай гэрээ байгуулсан боловч бараа нийлүүлэх хугацаа, үнийн дүн тодорхой бус, 30.2 сая төгрөгийн гэрээ байгуулж, төлбөрийг хуваан шилжүүлсэн
- Сэлбэг хэрэгсэл худалдан авах- Мөнх язгууртан ХХК-тай гэрээ байгуулалгүйгээр 15.3 сая төгрөгийг урьдчилж шилжүүлсэн.
- Хөдөлмөр хамгааллын хувцас нийлүүлэх- Өнөрбаян хайрхан ХХК-тай 10.8 сая төгрөгийн гэрээ байгуулан, төлбөрийг хуваан шилжүүлсэн.

3.2.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас 13 ажлын ТЭЗҮ-ийг боловсруулаагүй, үнэлгээний хорооны зарим гишүүд АЗ сертификатгүй, сонирхлын зөрчлийн маягт бөглөөгүй, тендерийг үнэлсэн маягт нотлох баримт байхгүй зөрчил нийтлэг байна.

3.3 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус, гэрээг дүгнээгүй, хүлээн авсан баримт материал хангалтгүй байна.

3.3.1 Тус байгууллага 2016-2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 35 ажлыг хийж гүйцэтгэсэн ба, эдгээрээс 2017 оны 2 ажлыг хүлээн аваагүй байна. Үүнд:

- SEL реленүүдийн захиалга – АР ПИ ЭНД ЭЙ ХХК-тай 19.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан, 13.6 сая төгрөгийг санхүүжүүлсэн, бараа материалыг бүрэн хүлээлгэн өгсний дараа үлдэгдэл төлбөрийг санхүүжүүлэхээр гэрээнд заасан байна. Гэвч гэрээнд бараа нийлүүлэх хугацааг тодорхой зааж өгөөгүйгээс одоо болтол бараа нийлүүлэгдээгүй байна.
- Аваарын нөөц бүрдүүлэх- Тендерт шалгуур хангасан оролцогч ирээгүй тул шууд гэрээ байгуулах эрхийг үнэлгээний хорооноос өгснөөр “Орд харш” ХХК-тай 149.3 сая төгрөгөөр гэрээ байгуулжээ. Гүйцэтгэгчид нийт төлбөрийн 90% буюу 134.4 сая төгрөгийг шилжүүлсэн боловч 121.3 сая төгрөгийн бараа нийлүүлжээ. Гэрээт хугацаанд бараагаа бүрэн нийлүүлээгүй тул Шүүхэд хандсан байна. Шүүхийн шийдвэрээр 2 тал эвлэрч 2018 оны 06 сарын 15-ны дотор нийлүүлэхээр эвлэрч хэргийг хэрэгсэхгүй болгожээ. Гэвч үлдэгдэл бараа материал ирээгүй байхад, ямар нэгэн арга хэмжээ авч ажиллахгүй байсаар байна.

3.3.2 Хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудтай газар дээр нь очиж үзэн, ажлын тоо хэмжээ, ТЭЗҮ, хүлээн авсан акт баримт материал, нярвын тайлан, агуулахын бүртгэлтэй тулгахад дараах зөрчил байна. Үүнд:

- "Аваарын нөөц бүрдүүлэх" 2016 оны ажлын хүрээнд Мөнх Язгууртан ХХК-тай гэрээ байгуулсан гэх боловч гэрээ аудитад хамрагдаагүй, ХАА-ны төсөвт өртгөөс 24.0 сая төгрөгөөр илүү тоног төхөөрөмж нийлүүлсэн.
- "Аваарын нөөц бүрдүүлэх" 2016 оны ажлын хүрээнд иргэн Даваамягмар, Батбилэг нараас 53.6 сая төгрөгийн худалдан авалт хийснийг, нярвын тайлантай тулган баталгаажуулахад 1.1 сая төгрөгийг хөрөнгө орлого аваагүй буюу илүү шилжүүлсэн байна



- Минпро ХХК-иас 10.0 сая төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авч ЭХЯ-д ойд бэлэглэсэн гэх боловч ТУЗ-ын зөвшөөрөлгүй, анхан шатны баримтгүй, нярвын тайланд орлого аваагүй шууд зардалд бичсэн байна.
- “Тайшир УЦС-ын орчны тохижилт”-ын ажлын ариун цэврийн өрөөний 1 душ алга болсон.
- “Тосонцэнгэл УЦС” ХХК-ийн хурдны тохируулга 945 об/мин, Чадлын банкийг шинэчлэх” ажлын хүрээнд төлөвлөгдсөн ажил хийгдээгүй, оронд нь 2 ш соронзон фускатель нийлүүлэгдсэн байна.
- “Аваарын нөөц бүрдүүлэх” ажлын хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг нярвын тайлан агуулахын бүртгэлтэй тулгахад 2ш 15кв-ын хуурай салгуурын оронд 10кв-ын хуурай салгуур ирсэн, 110 кв-ын 2ш травресс нийлүүлэгдээгүй байна.

3.3.3 Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлуудын гэрээний хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчил байна.

- Хөрөнгө оруулалтын ажлыг гэрээт хугацаанд нь хүлээлгэн өгөөгүй "Хар чонот" ХХК-иар 0.6 сая төгрөг, "Эрч чадал" ХХК-иар 0.8 сая төгрөг, "Блу Энержи" ХХК-иар 0.3 сая төгрөг, "АР ПИ ЭНД ЭЙ" ХХК-иар 0.87 сая төгрөг, "МСЛ" ХХК-иар 0.05 сая төгрөг нийт 2.6 сая төгрөгийн алдангийг төлүүлээгүй байна.
- 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөвт өртгөөс 42.0 сая төгрөгөөр илүү гэрээ байгуулж, 4 ажлыг (Жаргалан, Баян-Уул 15 кв-ын ЦДАШ-д холгогдож тасарсан 8км АС 50 марзын утас шинээр солих, 35кВ-ын вакуум таслуур нийлүүлэх, Р-635 маркны дизелийн инжектор, порсункууд нийлүүлэх, Шарга-Төгрөг, Бигэр Цогтын 15 кв-ын ЦДАШугамд урсгал засвар хийх) санхүүжүүлсэн, төсөвт өртөгт багтаж байгаа хэдий ч байгуулсан гэрээний үнийн дүнгээс 9.8 сая төгрөгөөр илүү шилжүүлсэн байна.
- Энжэн ХХК-тай байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус гарын үсэг тамга тэмдэггүй, Хоролбар ХХК, Хан Хэнтий, УАЗ Мега ХХК, Гантесла ХХК-тай байгуулсан гэрээнд хугацаа, үнийн дүн, алдангийн хэмжээг заагаагүй, Мөнх язгууртан ХХК, Сидан ХХК, иргэн Баянбаатартай байгуулсан гэрээ байхгүй аудитад хамрагдаагүй.
- Хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээн авах комисс томилогдоогүй, 2016 онд 9, 2017 онд 9, нийт 18 ажлыг хүлээн авсан акт үйлдээгүй байна. Энэ нь захиалагч талаас гэрээний хүлээн авах үүргээ биелүүлээгүйг харуулж байна.

3.4 Компанийн худалдан авах үйл ажиллагааны хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна

3.4.1 Компанийн 2016-2017 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дотоод хяналтын албанаас хяналт шалгалт хийхээр төлөвлөөгүй, хийгээгүй байна. Энэ нь МУ-ын Засгийн газрын 2015 оны 483-р тогтоол "Дотоод аудитын дүрэм"-ийн 5.1.3¹⁹ дахь заалт, Компанийн дотоод журмын 11.4²⁰ дэх заалтыг зөрчсөн байна.

¹⁹ 5.1.3. төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал;

²⁰ /Дотоод хяналтын алба нь дараах чиглэлүүдээр хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хууль дүрэм, журмыг мөрдүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, аливаа эрсдлээс урьдчлан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд 11.4.6 дахь заалт Санхүүгийн үйл ажиллагаа өмч хөрөнгийн бүртгэл тооцоо захиран зарцуулалт, ашиглалт хадгалалт хамгаалалт/

**ДҮГНЭЛТ**

АУЭХС ТӨХК”-ний 2016-2017 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Компанийн зорилтот түвшинд нийт зардал, алдагдлыг өндөр төлөвлөсөн, энергийн мэдээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргаагүй байна
- Аудитад хамрагдсан ажилчдын 28.5 хувь нь ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагуудыг хангахгүй байна.
- Компани санхүүгийн хувьд хараат, ашигт ажиллагааны хувьд алдагдалтай ажилласан байна.
- Хүний нөөц, техникийн нөөцийг уялдуулан тооцсон хүчин чадлаар ажиллавал ЦЭХ-ний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх боломжтой байна.
- Хэрэглэгчдэд ЦЭХ-ийг 11.3 төгрөг буюу одоо борлуулж байгаа үнээс 12%-иар бууруулах боломжтой байна
- Дотоод хяналт аудитын алба нь 2016 оныг эс тооцвол, техникийн болон хөдөлмөр хамгааллын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.
- Үйл ажиллагааны бус орлогыг нэмэгдүүлээгүй, санхүүгийн тайланд орлогыг илүү, дутуу тайлагнасан байна
- Албан татвар, хураамжийг улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.
- Хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгасан боловч, ТУЗ-ын тогтоол шийдвэргүйгээр 4.5 сая төгрөгийн хөрөнгөөр охин компаниудыг шагнасан байна.
- Үр дүнгийн урамшуулалд 580.4 сая төгрөгийг давхардуулан олгосон, ой, баяр ёслолын арга хэмжээнд 91.6 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг журмын дагуу тооцсон байна.
- Санхүүгийн үйл ажиллагаа, зарцуулалтад дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна
- Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлууд зайлшгүй шаардлагатай байсан хэдий ч төлөвлөгөөнд тусгагдаагүй 262.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна
- Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлын 37 хувьд, төлөвлөгдөөгүй хөрөнгө оруулалтын ажлын 65 хувьд худалдан авалтын сонгон шалгаруулалт хийгээгүй байна
- Компанийн хөрөнгө оруулалтын ажилд тавих дотоод хяналт байхгүйгээс хууль дүрэм, журам зөрчих, гэрээний үүргээ биелүүлэхгүй байх асуудлууд тулгарч байна
- Компанийн худалдан авах үйл ажиллагааны хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна

Аудитаар нийт 3,151.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 2,553.3 сая төгрөгийн зөрчилд 17 заалт зөвлөмж хүргүүлэн, 540.9 сая төгрөгийн зөрчилд 37 заалт албан шаардлага, хариуцлага тооцох 13 албан тушаалтанд хүргүүлэн, орон нутгийн орлогод 56.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, хувь хүнд буцаан олгох 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,500.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 45 санхүүгийн бус үр өгөөж бүртгэлээ.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



САНАЛ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна

Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газарт

- “АУЭХС” ТӨХК-ийн санхүүгийн тайланг баталгаажуулахдаа эрсдэлтэй асуудлуудыг анхаарч үзэх

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

“АУЭХС” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлд

- Компанийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах саналыг харгалзан үзэн, үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөг бодитой батлах
- Төсвийн хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй байхаар баталж байх

“АУЭХС” ТӨХК-ийн Гүйцэтгэх захиралд

- Стандарт, заавар журамд нийцүүлэн үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх
- Үйл ажиллагааны бус орлогыг нэмэгдүүлж ажиллах
- Он дамжсан авлага өглөгийг тооцоо нийлж барагдуулах арга хэмжээ авч ажиллах

“АУЭХС” ТӨХК-ийн Дэд даргад

- Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд хугацаа, үнэ, хариуцлагын талаарх заалтыг тодорхой оруулж гэрээг баталгаажуулж, хугацаанд нь дүгнэж ажиллах
- Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллаж байх

“АУЭХС” ТӨХК-ийн Дотоод хяналын албаны даргад

- Хөрөнгө, бараа материалын худалдан авалт хууль журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах

“АУЭХС” ТӨХК, Завхан аймаг дахь салбар, Тайшир Гуулин УЦС ХХК, Богдын голын УЦС ХХК, Тосонцэнгэл УЦС ХХК-ийн захирал нарт

- Орлогыг стандарт, заавар журамд нийцүүлэн үнэн зөв бүртгэж, тайлагнаж ажиллах



Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл /хуулийн заалтаар/

№	Огноо	Илэрсэн зөрчлийн утга	Зөрчил гаргасан албан тушаалтан	Аудитаар авсан арга хэмжээ
Орлогын талаар				
1	2014-2017	Хогны төлбөрийн орлого 57.8 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн, үйл ажиллагааны бус орлого нэмэгдүүлэх боломжийг ашиглаагүй	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, нягтлан бодогч Д.Нарантуяа	“Үйл ажиллагааны бус орлогыг нэмэгдүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх” зөвлөмж хүргүүлэв
2	2014-2017	Хогны төлбөрийн орлогын тооцоог хийхэд гэрээний дагуу 2016 онд 0.57 сая төгрөг, 2017 онд 0.1 сая төгрөгийн нийт 0.674 сая төгрөгийн алдангийг ЕБ-ын ОНЕО-д төвлөрүүлээгүй байна.	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, нягтлан бодогч Д.Нарантуяа	“Гэрээний дагуу тооцсон алданги 0.674 сая төгрөгийг ЕБ сумын ОНЕО-д 2018 оны 12 сарын 15-ны дотор төвлөрүүлэх” төлбөрийн акт тогтоов
3	2016-2017	Телевизийн хураамж 27.4 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн, гэрээний дагуу 11.5 сая төгрөгийн алдангийг төлөөгүй	“АУЭХС” ТӨХК-ны дэд захирал Д.Отгонбаяр, Ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг, Борлуулалтын хэлтсийн дарга Д.Алтанцэцэг, Завхан аймаг дахь салбарын Дарга Г.Бадамхатан, нягтлан бодогч Д.Жаргалтуяа	“Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллаж байх” зөвлөмж хүргүүлэв
4	2016-2017	“АУЭХС” ТӨХК-ны системийн хэмжээнд банктай байгуулсан харилцах дансны гэрээ байгаа эсэх нь тодорхой бус аудитад АУЭХС ТӨХК-ийн харилцах дансны гэрээ хамрагдаагүй, зарим гэрээг 0 хувийн хүүтэйгээр байгуулсан нь арилжааны банкинд давуу байдлыг бий болгосон гэрээ болжээ.	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг,	“Арилжааны банкуудтай байгуулсан гэрээгээ дахин хийж, биелэлтийг 2018 оны 12 сарын 15-ны дотор ирүүлэх” албан шаардлага хүргүүлэв
5	2016-2017	Үр дүнгийн тайланд орлогыг хүлээн зөвшөөрч тайлагнаагүй, мөнгөн гүйлгээний тайланд орлогуудыг зөрүүтэй тайлагнасан байна.	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг, Завхан аймаг дахь салбарын Дарга Г.Бадамхатан, нягтлан бодогч Д.Жаргалтуяа, “Тайшир Гуулин УЦС” ХХК-ны Гүйцэтгэх захирал Д.Амартүвшин, Нягтлан бодогч Г.Ганчимэг, “Тосонцэнгэл УЦС” ХХК-ний Гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэг, нягтлан	“Орлогыг стандарт, заавар журамд нийцүүлэн үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх” зөвлөмж хүргүүлэв



			бодогч Б.Өлзийсайхан, Богдын Гол УЦС ХХК-ны Дарга Ц.Улам-Оргих, нягтлан бодогч Ч.Уугангэрэл	
Хөрөнгө оруулалтын талаар				
6	2016	2016 оны "Аваарын нөөц бүрдүүлэх" ажлын хүрээнд төсөвт өртгөөс илүү 24.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн, тендерт шалгараагүй иргэнээс 53.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, 1.1 сая төгрөгийг илүү шилжүүлсэн байна	"АУЭХС" ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг	1. "Илүү шилжүүлсэн 1.15 сая төгрөгийг суутган тооцож, 2018 оны 12 сарын 15-ны дотор татварын бус орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх" төлбөрийн акт тогтоох 2. Хөрөнгө оруулалтын ажлыг төсөвт багтаан хуулийн дагуу тендерт шалгарсан иргэн ААН-ээр гүйцэтгүүлэх" албан шаардлага хүргүүлэв
7	2016-2017	Хөрөнгө оруулалтын ажлыг гэрээт хугацаанд нь хүлээлгэн өгөөгүй "Хар чонот" ХХК-иар 0.61 сая төгрөг, "Эрч чадал" ХХК-иар 0.78 сая төгрөг, "Блу Энержи" ХХК-иар 0.32 сая төгрөг, "АР ПИ ЭНД ЭЙ" ХХК-иар 0.87 сая төгрөг, "МСЛ" ХХК-иар 0.054 сая төгрөг нийт 2,63 сая төгрөгийн алдангийг төлүүлээгүй байна.	АУЭХС ТӨХК-ны дэд захирал Д.Отгонбаяр, Ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг, нягтлан бодогч С.Бадамцэрэн	"Гэрээт хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүйд тооцсон алданги 2.63 сая төгрөгийг 2018 оны 12 сарын 15-ны дотор татварын бус орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх" төлбөрийн акт тогтоов
8	2017	Минпро ХХК-иас 10.0 сая төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан боловч, анхан шатны баримтгүй, нярвын тайланд орлого аваагүй шууд зардалд бичсэн байна.	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг	"Шууд зардалд бичсэн 10.0 сая төгрөгийг 2018 оны 12 сарын 15-ны дотор татварын бус орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх" төлбөрийн акт тогтоов
9	2016	Эд хариуцагчийн тайланд орлого аваагүй 1.64 сая төгрөгийн материалыг үнийг илүү шилжүүлсэн байна.	"Богдын голын УЦС" ХХК-ны Гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэг, нягтлан бодогч Б.Өлзийсайхан	"Шууд зардалд бичсэн 1.64 сая төгрөгийг 2018 оны 12 сарын 15-ны дотор татварын бус орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх" төлбөрийн акт тогтоов
10	2016-2017	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөвт өртгөөс илүү 42,0 сая төгрөгөөр гэрээ байгуулж, 4 ТАХ-г санхүүжүүлсэн, 9.8 сая төгрөгийг 1 ажлыг гэрээний үнийн дүнгээс илүү санхүүжүүлсэн байна.	Дотоод хяналтын албаны дарга Б.Наваанюндэн	"Хөрөнгө, бараа материалын худалдан авалт хууль журмын явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах" албан шаардлага хүргүүлэв



11-12	2016-2017	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 30 ТАХ-ээс 5 ажилд худалдан авах ажиллагаа тендер шалгаруулалт хийгээгүй, 13 ТАХ-ний ТЭЗҮ-ийг боловсруулаагүй, үнэлгээний хорооны зарим гишүүд АЗ сертификатгүй, сонирхлын зөрчлийн маягт бөглөөгүй, тендерийг үнэлсэн маягт нотлох баримт байхгүй, Төсөвт өртөг 10.0 сая төгрөгөөс дээш, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, 6 ТАХ-нд тендер зарлаагүй, 169.3 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.	Дотоод хяналтын албаны дарга Б.Наваанюндэн	“Хөрөнгө, бараа материалын худалдан авалт хууль журмын явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах” албан шаардлага хүргүүлэв
13		Тайшир УЦС-ын орчны тохижилт”-ын ажлын ариун цэврийн өрөөний 1 душ алга болсон	Гүйцэтгэх захирал Д.Амартүвшин, Нягтлан бодогч Г.Ганчимэг	Алга болсон хөрөнгө 300.0 мянган төгрөгийг 2018 оны 12 сарын 15-ны дотор татварын бус орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов
14	2016-2017	“Тосонцэнгэл УЦС-ын хурдны тохируулга 945 об/мин, Чадлын банкйг шинэчлэх” ажлын хүрээнд төлөвлөгдсөн ажил хийгдээгүй, оронд нь 2 ш соронзон фускатель нийлүүлэгдсэн, “Аваарын нөөц бүрдүүлэх” ажлын хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг нярвын тайлан агуулахын бүртгэлтэй тулгахад 2ш 15кв-ын хуурай салгуурын оронд 10кв-ын хуурай салгуур ирсэн, 110 кв-ын 2ш травресс нийлүүлэгдээгүй байна.	Дотоод хяналтын албаны дарга Навааюндэн	“Хөрөнгө оруулалтын ажлуудад хяналт тавьж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллах” албан шаардлага хүргүүлэв
15-16	2016-2017	Хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээн авах комисс томилогдоогүй, Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус, гэрээнд үнэ, хугацаа байхгүй, зарим гэрээ аудитад хамрагдаагүй	АУЭХС ТӨХК-ны дэд захирал Д.Отгонбаяр, ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг	“Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд хугацаа, үнэ, хариуцлагын талаарх заалтыг тодорхой оруулж гэрээг баталгаажуулж, хугацаанд нь дүгнэж байх” албан шаардлага хүргүүлэв
17	2017	"SEL реленүүдийн захиалга", "Аваарын нөөц бүрдүүлэх" 2017 оны 2 ажлыг хүлээн аваагүй байна	АУЭХС ТӨХК-ны дэд захирал Д.Отгонбаяр	“Гэрээний үүргээ биелүүлээгүй 2 компанийг 2018 оны 12 сарын 15-ны дотор Шүүхийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэн, холбогдох баримт материалыг ирүүлэх” албан шаардлага хүргүүлэв



18	2016-2017	Үндсэн хөрөнгө, бараа материал хүлээн авсан баримтгүй, тооллогоор хөрөнгө дутагдсан, илүүдсэн, нягтлан бодогчтой тооцоо нийлж тулган баталгаажуулалт хийгээгүй, нярвын тайлан зөрүүтэй, агуулахын бүртгэлийг тухай бүр хөтлөөгүй байна	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн	“Ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн эд хариуцагч Т.Ариунжаргал, С.Хүрэлбаатар нарт хариуцлага тооцох” санал хүргүүлэв
Зардлын зарцуулалтын талаар				
19	2016-2017	Үндсэн цалинг, амралтын цалин давхардуулан 4.5 сая төгрөгийг олгосон байна.	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, тооцооны нягтлан бодогч Д.Бадамцэрэн, Д.Нарантуяа, хүний нөөцийн ажилтан Б.Оюунбилэг, Завхан аймаг дахь салбарын Дарга Г.Бадамхатан, нягтлан бодогч Д.Жаргалтуяа, “Тайшир Гуулин УЦС” ХХК-ны Гүйцэтгэх захирал Д.Амартүвшин, Нягтлан бодогч Г.Ганчимэг	Илүү олгосон цалин 4.5 сая төгрөгийг суутган тооцож, 2018 оны 12 сарын 15-ны дотор татварын бус орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов
20	2016-2017	Цалинг 1.2 сая төгрөгөөр илүү, 0.22 сая төгрөгөөр дутуу, томилолтын зардлыг 0.025 сая төгрөгөөр тус тус илүү олгосон	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, тооцооны нягтлан бодогч Д.Бадамцэрэн, Д.Нарантуяа, “Тосонцэнгэл УЦС” ХХК-ний Гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэг, нягтлан бодогч Б.Өлзийсайхан	<ol style="list-style-type: none"> 1. “Дутуу олгосон цалин 0.3 сая төгрөгийг ажилчдад буцаан олгох” төлбөрийн акт тогтоов 2. “Илүү олгосон цалин 1.2 сая төгрөгийг суутган тооцож, 2018 оны 12 сарын 15-ны дотор татварын бус орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх” төлбөрийн акт тогтоов 3. “Илүү олгосон 0.025 сая төгрөгийг 2018 оны 12 сарын 15-ны дотор татварын бус орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх” төлбөрийн акт тогтоох
21	2016-2017	Ажиллагсдад олгосон 12.0 сая төгрөгийн цалингийн урамшууллаас НДШ суутгаагүй, төлөөгүй	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, тооцооны нягтлан бодогч Д.Бадамцэрэн, Д.Нарантуяа	“Ажилчдын 12.1 сая төгрөгийн цалинг Нийгмийн даатгалд нөхөн тайлагнах” албан шаардлага хүргүүлэв



22	2016-2017	Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчдөөс авсан бараа материалын 10 хувь 278.6 сая төгрөгийг НӨАТ-ын тайланд тусгаагүй байна.	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, тооцооны нягтлан бодогч Д.Бадамцэрэн, Д.Нарантуяа	“НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах” албан шаардлагыг хүргүүлэв
23	2016-2017	Хувь хүнээс бараа материал худалдан авсан бөгөөд татвар 3.0 сая төгрөгийг суутгаагүй шилжүүлсэн	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг, Завхан аймаг дахь салбарын Дарга Г.Бадамхатан, нягтлан бодогч Д.Жаргалтуяа, “Тайшир Гуулин УЦС” ХХК-ны Гүйцэтгэх захирал Д.Амартүвшин, Нягтлан бодогч Г.Ганчимэг, “Тосонцэнгэл УЦС” ХХК-ний Гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэг, нягтлан бодогч Б.Өлзийсайхан, Богдын Гол УЦС ХХК-ны Дарга Ц.Улам-Оргих, нягтлан бодогч Ч.Уугангэрэл	“Суутгаагүй татвар 3.0 сая төгрөгийг 2018 оны 12 сарын 15-ны дотор татварын бус орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх” төлбөрийн акт тогтоов
24	2016-2017	Анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад гүйлгээ хийсэн 16.1 сая төгрөгийн зөрчил байна.	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, тооцооны нягтлан бодогч Д.Бадамцэрэн, Д.Нарантуяа	“Анхан шатны баримтгүй гүйлгээ хийдэг явдлыг таслан зогсоох” албан шаардлага хүргүүлэв
25	2016-2017	Өглөг, авлага 168.7 сая төгрөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй, 1.0 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг томилолтын зардалд тайлагнасан	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, тооцооны нягтлан бодогч Д.Бадамцэрэн, Д.Нарантуяа, “Тайшир Гуулин УЦС” ХХК-ны Гүйцэтгэх захирал Д.Амартүвшин, Нягтлан бодогч Г.Ганчимэг	1. “Он дамжсан авлага өглөгийг тооцоо нийлж барагдуулах арга хэмжээ авч ажиллах” 2. “НББ-ийн бодлогын баримт бичгийг баримталж ажиллаж байх” албан шаардлага хүргүүлэв
26	2016-2017	Жолоочийн тооцооны хуудсыг хянахад 3.1 сая төгрөгийн шатахууныг нормоос илүү зарцуулсан	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг, Завхан аймаг дахь салбарын Дарга Г.Бадамхатан, нягтлан бодогч Д.Жаргалтуяа, Богдын Гол УЦС ХХК-ны Дарга Ц.Улам-Оргих, нягтлан бодогч Ч.Уугангэрэл	“Илүү зарцуулсан 3.1 сая төгрөгийн шатахууныг 2018 оны 12 сарын 15-ны дотор татварын бус орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх” төлбөрийн акт тогтоов
27	2016-2017	Жолоочийн шатахууны замын хуудас бичээгүй,	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, ерөнхий	1. “Ажлын хариуцлага алдсан нягтлан бодогч Т.Дэлгэрмаа,



		тооцоо бодоогүй ажлын хариуцлага алдсан байна.	нягтлан бодогч С.Ганзориг, Завхан аймаг дахь салбарын Дарга Г.Бадамхатан, нягтлан бодогч Д.Жаргалтуяа,” Богдын Гол УЦС ХХК-ны Дарга Ц.Улам-Оргих, нягтлан бодогч Ч.Уугангэрэл	Д.Нарантуяа, тооцооны хуудас хөтлөөгүй жолооч Э.Алтайсаруул, Энхбаатар, Нармандах нарт хариуцлага тооцох” албан шаардлагыг хүргүүлэв 2. “Жолоочийн замын хуудсыг батлагдсан загвар маягт стандартын дагуу үнэн зөв хөтлүүлж, тооцоог бодоогүй Ахлах нягтлан бодогч Д.Жаргалтуяа, тооцооны нягтлан бодогч Б.Эрдэнэсоёл нарт хуулийн дагуу хариуцлага тооцох” албан шаардлагыг хүргүүлэв 3. “Жолоочийн замын хуудсыг батлагдсан загвар маягт стандартын дагуу үнэн зөв хөтлүүлж, тооцоог бодоогүй нягтлан бодогч Ч.Уугангэрэлд хуулийн дагуу хариуцлага тооцох” албан шаардлагыг хүргүүлэв
28	2016-2017	Татварын хэлтэст тайлагнасан тайлангууд 7.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	Завхан аймаг дахь салбарын Дарга Г.Бадамхатан, нягтлан бодогч Д.Жаргалтуяа,” Богдын Гол УЦС ХХК-ны Дарга Ц.Улам-Оргих, нягтлан бодогч Ч.Уугангэрэл	“Татварын тайланг залруулан үнэн зөв гаргаж, биелэлтийг 2018 оны 12 сарын 1-ны дотор ирүүлэх ” албан шаардлагыг хүргүүлэв.
29	2016-2017	Тооллогоор 0.8 сая төгрөгийн бараа материал, хөрөнгө дутагдсан	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, тооцооны нягтлан бодогч Д.Нарантуяа, нярав Т.Ариунжаргал, С.Хүрэлбаатар, Тайшир Гуулин УЦС ХХК-ны Гүйцэтгэх захирал Д.Амартүвшин, Нягтлан бодогч Г.Ганчимэг	“Дутагдсан бараа материал 0.8 сая төгрөгийг 2018 оны 12 сарын 15-ны дотор татварын бус орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх” төлбөрийн акт тогтоов
30	2016-2017	Ажиллагсдад 31.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг картлуулж өгөөгүй байна.	Тайшир Гуулин УЦС ХХК-ний Гүйцэтгэх захирал	“Хөрөнгийг картлуулан бүртгэлд тусган, хяналт тавьж ажиллах албан шаардлага



			Д.Амартүвшин, Нягтлан бодогч Г.Ганчимэг	хүргүүлэх” албан шаардлага хүргүүлэв.
31	2016-2017	УИХ-ын тогтоолыг зөрчин, 2016-2017 онд 27.4 сая төгрөгийг шинэ жилийн арга хэмжээнд үр ашиггүй зарцуулжээ.	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг, Завхан аймаг дахь салбарын Дарга Г.Бадамхатан, нягтлан бодогч Д.Жаргалтуяа, “Тайшир Гуулин УЦС” ХХК-ны Гүйцэтгэх захирал	“Баяр ёслолд зарцуулсан 27.4 сая төгрөгийг 2018 оны 12 сарын 15-ны дотор татварын бус орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх” төлбөрийн акт тогтоов.
32	2016-2017	Тус систем компани нь 2016-2017 онд 63.5 сая төгрөгийг бусад баяр ёслолд /ой, ЭХ-ний ажилчдын баяр, март 8/ үр ашиггүй зарцуулжээ.	Д.Амартүвшин, Нягтлан бодогч Г.Ганчимэг, “Тосонцэнгэл УЦС” ХХК-ний Гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэг, нягтлан бодогч Б.Өлзийсайхан, Богдын Гол УЦС ХХК-ны Дарга Ц.Улам-Оргих, нягтлан бодогч Ч.Уугангэрэл	“Төсвийн хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах” албан шаардлага хүргүүлэв
33	2016-2017	Ажиллагсад “сарын үр дүнгийн урамшуулал”-аас гадна 2016 онд 221.9 сая төгрөг, 2017 онд 358.5 сая төгрөг нийт 580.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.	Д.Амартүвшин, Нягтлан бодогч Г.Ганчимэг, “Тосонцэнгэл УЦС” ХХК-ний Гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэг, нягтлан бодогч Б.Өлзийсайхан, Богдын Гол УЦС ХХК-ны Дарга Ц.Улам-Оргих, нягтлан бодогч Ч.Уугангэрэл	“Төсвийн хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй байхаар баталж байх” зөвлөмжийг ТУЗ-д хүргүүлэв.
34	2016-2017	Санхүүгийн тайлан зөрүүтэй, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, харилцагч байгууллагатай тооцоо нийлж тулган баталгаажуулаагүй, хөрөнгө оруулалтын ажлуудыг гүйцэтгэлийг харгалзан санхүүжүүлээгүй, хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, арилжааны банктай байгуулсан харилцах дансны гэрээг аудитад хамруулаагүй	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, Ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг	Зөрчил гаргасан Ерөнхий нягтлан бодогч С.Ганзоригт хариуцлага тооцох” албан шаардлага хүргүүлэв
Бусад үйл ажиллагаа				
35	2016-2017	Батлагдсан орон тооноос Тосонцэнгэл УЦС ХХК нь 2 орон тоогоор, Завхан салбар нь 2 орон тоогоор нийт 7 орон тоо илүү ажиллуулж байна.	Завхан аймаг дахь салбарын Дарга Г.Бадамхатан, нягтлан бодогч Д.Жаргалтуяа “Тосонцэнгэл УЦС” ХХК-ний Гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэг,	“Орон тоо илүү ажиллуулсан, төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллаагүй Завхан салбарын дарга Г.Бадамхатан, Тосонцэнгэл УЦС-ын дарга Н.Оюунцэцэг нарт хариуцлага тооцох” албан шаардлага хүргүүлэв
36	2016-2017	Цалингийн зардлыг 332.4 сая төгрөгөөр үр ашиггүй зарцуулсан, борлуулж байгаа цахилгааны дундаж үнийг 11.3 төгрөг буюу 12 хувиар бууруулах, цахилгаан эрчим хүчний өртгийг 24.3 төгрөг буюу 13.5 хувиар бууруулах, алдагдлыг 13 төгрөг буюу 16.5 хувиар бууруулах боломжтой байна.	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг, Завхан аймаг дахь салбарын Дарга Г.Бадамхатан, нягтлан бодогч Д.Жаргалтуяа “Тосонцэнгэл УЦС” ХХК-ний Гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэг, нягтлан бодогч Б.Өлзийсайхан,	“Компанийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах саналыг харгалзан үзэн, үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөг бодитой батлах” зөвлөмжийг ТУЗ-д хүргүүлэв



37	2016-2017	Компанийн зорилтот түвшний биелэлтийг зөрүүтэй мэдээлсэн	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, эдийн засагч А.Төгсбаяр	“ТЭЗҮ болон үйлдвэрлэлийн мэдээг үнэн бодитой, мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх” албан шаардлагыг хүргүүлэв
38	2016-2017	Борлуулалтын программын мэдээллийг тулгахад хэрэглэгчийн цахилгааны төлсөн мөнгийг зөрүүтэй тооцсон	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, Борлуулалтын хэлтсийн дарга Д.Алтанцэцэг, нягтлан бодогч Т.Дэлгэрмаа	“Борлуулалтын программыг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах албан шаардлага хүргүүлэх” албан шаардлага хүргүүлэв.
39	2016-2017	Ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөс батлагдсан ажлын байрны тодорхойлолтын загварын дагуу боловсруулж мөрдөөгүй, ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлагыг хангахгүй давхардсан тоогоор 55 ажилтан ажиллаж байна	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, хүний нөөцийн ажилтан Б.Оюунбилэг	1. “Төрийн албаны зөвлөлийн баталсан зааврын дагуу ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, баталж, мөрдүүлж ажиллах” 2. “Батлагдсан ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлагыг хангасан ажилтныг авч ажиллуулах” албан шаардлага хүргүүлэв.
40	2016-2017	Гэрээний дэвтэр 17.0 сая төгрөгийг орлого аваагүй, Хандиваар 4.5 сая төгрөгийн компьютер шилжүүлэхдээ ТУЗ-ын тогтоол гаргуулаагүй, Истана машиныг бүртгэлд тусгаагүй,	АУЭХС ТӨХК-ний гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, Ерөнхий нягтлан бодогч С.Ганзориг	“Хөрөнгийг данс бүртгэлд тусган, өөрт олгогдсон эрхийн хэмжээнд шийдвэр гарган, эзэмшиж ашиглах албан шаардлага хүргүүлэх” албан шаардлага хүргүүлэв
41	2016-2017	Дотоод хяналтын албаны санхүүгийн чиглэлээр хийсэн хяналтын ажил хангалтгүй, салбар охин компани тус бүрд шалгалт хийх төлөвлөгөө байхгүй, хяналт шалгалтын хийсэн ажлын биелэлтийг бодит байдлаар тооцож ажиллаагүй байна.	Гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн, Дотоод хяналтын албаны дарга Навааюндэн, Аудитор Баянжаргал	“Төлөвлөгөө гаргаж хяналт тавьж ажиллах” албан шаардлага хүргүүлэв
42	2016-2017	Дотоод хяналтын албаны архив бичиг хэрэгт 2016 оны хууль эрх зүй, санхүүгийн чиглэлээр өгсөн зөвлөмж, шийдвэрүүдийн материал байхгүй аудитаар хамрагдаагүй, хөрөнгө оруулалтын ажлуудад хяналт тавьж ажиллаагүй байна.	Гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн	Зөрчил гаргасан албан үүргээ хангалтгүй биелүүлсэн гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэнд хариуцлага тооцох” албан шаардлага хүргүүлэв
43	2016-2017	Батлагдсан орон тооноос АУЭХС ТӨХК нь 3 орон		



		тоогоор илүү хүн ажиллуулсан,		
44	2016-2017	Систем компанийн хөндлөнгийн хяналт шалгалтаар өгөгдсөн шийдвэрийн хэрэгжилтийг биелүүлсэн эсэхийг давтан тооцоолоход 2011 оны ГА-ын шийдвэрийн хэрэгжилт 50%, 2014 оны ГА-ын шийдвэрийн хэрэгжилт 59.6%-тай, 2016 оны СТА-ын шийдвэрийн хэрэгжилт 45%-тай, 2017 оны СТА-ын шийдвэрийн хэрэгжилт 17%-тай байгаа нь хангалтгүй байна.		



Холбогдох байгууллагын санал



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн манай компанийн 2016-2017 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад аудитын тайланд оруулах саналыг хавсралтаар гаргаж хүргүүлэв. Хавсралтыг хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

А.ПҮРЭВСҮРЭН

4	УИХ-ын тогтоолыг эргэн 2016-2017 онд 82.4 сая төгрөгийн шана жай, ой-арса хэвээнд үр ашгийг зарцуулжээ.	нөлөө боломжгүй болно. Баяр ёслолын зардалд зарцуулсан 82.4 сая төгрөгийн зардлыг ТУЗ-иас багасгасан зардлын дагуу хамтын гэрээнд заагдсан аашгүй үндэслэн зарцуулсан тул ашиг хүлээн авахаархгүй байна. Ман ахмадын баярын зардал болон хүүхдийн баярын арга хэмжээнд зарцуулсан зардал нь ахмад настны тусгай хуулийн дагуу зарцуулагдсан болно.
5	Жлоосний шатахууны амьтн хуудас бичээгүй тосгоо бодсогүй эрхлэн хармцлага алдсан байна.	Тосгооны нягтлан бодогч болон жлоосч нэрт хармцлага тооцоо арга хэмжээг эрхлэн ариутгах албан шаардлага болж өөрчлөх ашигийг хүч байна.
6	Эд харенгийн тооллого мйхэд 517.1 мянган төгрөгийн бараа материал дутагдав.	Шаардах хуудас бичигдээгүй, захирал болон өрөөнийг нягтлан бодогчор гарын үсэг зургадгагүй шаардах байсан. Хүмүүс амраад явсан байсан нь нэлээд олон үүнийг хангаж өгнө үү.

“Алтай-Увастайн Эрчим Хүчний Систем ТӨХК”

Говь-Алтай аймаг дахь төрийн аудитын газарт санал хүргүүлэх тухай

Аудитаар гарч байгаа зөвлөмж, шавилдлын дагуу шийдэл төсөрхий эхлэл зохион байгуулж ажиллгийн орлогог чамалдуулж үр ашгийг дээшлүүлж, програм хангамжийн шинэчлэлт, дэвшилтэт төв-оргоныг нэвтрүүлэн ажиллах болно.

Холны талбарийн орлогын 2014-2015 оны алдасыг 3.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтын ажилг гэрээний хугацаанд нийлүүлээгүй Хар нонот ХХК-иар 0.51 сая төгрөг, Эрч чадал ХХК-ийг 0.78 сая төгрөг, Буу-анерий ХХК-иар 0.32 сая төгрөг, Ар Па Энд, Зя ХХК-ээр 0.67 сая төгрөг, МСН ХХК-иар 0.054 сая төгрөг нийт 2.83 сая төгрөг, Метро ХХК-нд нийлүүлсэн 10.0 сая төгрөг, Баяр ёслолын зардалд зарцуулсан 82.4 сая төгрөгийн ашын талбарийг төлөх боломжгүй байна.

Мөн жлоосний тосгоо болон шатахууны зардалтай холбоотой тосгооны нягтлан бодогч Т.Дангэрмаа, Д.Нарантула, тосгооны хуудас хангаасгүй жлоосч З.Алтайсаруул, Энхбаттар, Нарандах, эд хармцлагч Т.Арвинжаргал, С.Хүрэлбаатар нарт хармцлага тооцоо албан шаардлага болж өөрчлөх ашигийг зарцуулж ажиллах албан шаардлага болж өөрчлөх ашигийг хүч байна.

Д/д	Илэрсэн ажил	Тайлбар
1	Холны талбарийн орлогын тосгоо ажилг гэрээний хугацаанд 2014 онд 1860.2, 2015 онд 1814.3, 2016 онд 570.1, 2017 онд 104.4 нийт 4349.0 мянган төгрөгийн алданыг төвлөрүүлэх	2012 онд багасгасан хөг хамтдын тухай хууданд орлоо мөрдөгдөх шана хуулийн зохицуулалт байгуул байсан бөгөөд анх 2014 онд байгуулсан гэрээ нэ гурвантлын журмаар байгуулж ажиллаж байсан бөгөөд гэрээ сунгаагүй байсан учраас 2014-2015 оны алдасын талбарийг хүлээн авахаархгүй байна. Мөн татаарын улсын байдалын ах талбар тавьн талыг барагдуулсан болно. Хөг хамтдын тухай шинэчлэн багасгасан хуулийн дагуу 47.1 дээ ааштын дагуу 2017 оноос гэрээ шинээр байгуулж манай байгууллага 25%-ийг авдаг байсан 15% болж бууруулсан нь Ёсбибулаг сумын төсвийн орлогод болж н гэрээ хувь намар болж байна. Харин 2016-2017 оны 670.0 мянган төгрөгийн алданыг төвлөрөх хүлээн авахаарх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах саналтай байна.
2	Хөрөнгө оруулалтын нөхцөл гэрээний хугацаанд нийлүүлээгүй Хар нонот ХХК-иар 0.61 сая төгрөг, Эрч чадал ХХК-ийг 0.78 сая төгрөг, Буу-анерий ХХК-иар 0.32 сая төгрөг, Ар Па Энд, Зя ХХК-иар 0.67 сая төгрөг, МСН ХХК-иар 0.054 сая төгрөг нийт 2.83 сая төгрөгийн алданыг	Манай компанийн хуудас эрчим хүчний компани учраад тэнэг төхөөрөмжийг дотооддоо нийлүүлж боломжгүй тэнэг төхөөрөмж их байдаг. Голцуу гадаргалд импортлогч нийлүүлэгч үр-арво хугацааны хуудас хандсан Баруу материалла бүрэн нийлүүлсэн учраас алдээр компанийн алданыг тооцож ажил боломжгүй байна.
3	Метро ХХК-иас 10.0 сая төгрөгийн болж дурсгалын зүйл худалдсан явсан болж, анхан шатны баримтгүй, нэрвэн тайланд орлого авалгүй шууд зардалд өмссөн	Метро ХХК-нд нийлүүлсэн 10.0 сая төгрөг нь эрчим хүчний орлого 15 жлоосч ойд болж дурсгалын зүйлийг бэлтгэж ажил үүрэг өгөгдсөний дагуу гэрээ байгуулж гэрээ үндэслэн шууд зардалд бүртгэсэн. Манай компанид болж дурсгалын зүйл илээгүй шууд явсанд нийлүүлэгчид учраас бид орлого авч ажиллах саналтай байна.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.БИШВИНСАРХАН

Манай байгууллагаас 2016-2017 оны үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн орлогог эрхлэн ариутгах зорилгоор эхлэл зохион байгуулж ажиллаж байна. Манай ашын талбар болж өөрчлөх ашигийг хүч байна. Манай ашын талбар болж өөрчлөх ашигийг хүч байна. Манай ашын талбар болж өөрчлөх ашигийг хүч байна.

НИЯГЛАН БОДООГЧ

Б.БИШВИНСАРХАН



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ
 “ТАЙШИР-ГУУЛИН УСАН ЦАХИЛГААН
 СТАНЦ” ХЭН ААГЗАГ ДМАЛ
 ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙ
 12091 Хэрэн хот, Говьсүмбэр сум, Говьсүмбэр аймаг
 Утас/факс: (70440-00)
 2018.10.11 № 102
 Ганцагч _____
 -ны № _____

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Танай байгууллагаас компаний 2016, 2017 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын явцад гарсан зөрчлийг залруулан дараах арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

- Ажиллагсдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулсан 2016 онд 175,6 мянган төгрөгийг тухайн холбоотой хүмүүсээс суутган шилжүүлэх.
- Шатахууны зарцуулалтыг жолоочийн замын хуудас, анхан шатны баримттай тулган гүйлгээг хийж байх
- Хятад хэлний орчуулагчийн ажлын хөлсний ХХОАТ-г суутган троцдох.
- Эд хөрөнгийн тооллого хийхэд Тайшир ҮЦС-д байрлаж ажиллах ажил ихтэй байсан тул тухайн сарын шаардах хуудас бичигдэж тайлан хийгдээгүй байсан. Энэ нь бараа материал дутагдах шалтгаан болсон тул цаашид хөдөө орон нутагт ажиллах ажлаа зөв хуваарилан анхаарч 299,8 мянган төгрөгийн дутагдсан бараа материалын зарцуулалтыг нэг бүрчлэн шалгах, анхан шатны баримтгүйгээр 155,0 мянган төгрөгийн гэрэл, 90,0 мянган төгрөгийн гэрлийн шилэйг ҮЦС-д суурилуулсан тул баримтуудыг бүрдүүлэн, нарав болон цахилгааны инженер, РХА инженер нарт холбогдох арга хэмжээг авлаа. Бусад дутагдсан бараа материалыг буруутай албан тушаалтануудаар төлүүлэх.
- Аж ахуйн хашааны ариун цэврийн ерөөний халуун усны бойлер “Бүрэндуулга-Алтай” ХХК-ий заруулын буруугаас алдагдсан байсныг төлүүлэн, буцааж суурилуулав.
- УИХ-ын тогтоол зөрчин 2016-2017 онуудад баяр ёслол, шөно жилд үр ашиггүй зарцуулсан гэх 5310,5 мянган төгрөгийг “АУЭХС” ТӨХК болон ТУЗ зэрэг эрх бүхий байгууллагуудаас хүлээн зөвшөөрч баталсан зардалд багтаан зарцуулсан тул актаас чөлөөлж өгнө үү. Цаашид энэ талаар анхаарч дээрх зөрчлүүдийг гаргалгүй ажиллах болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Х.Нуртөвшин
 ДАМАРТҮВШИН
 2018.10.23



Танайхаас ирүүлсэн хүсэлттэй танилцаад дараах тайлбарыг хүргүүлж байна.

№	Ирүүлсэн хүсэлт	Тайлбар
I	“АУЭХС” ТӨХК	
1	“Хогны төлбөрийг гэрээт хугацаанд төвлөрүүлээгүйд 4.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 2014-2015 оны 3.6 сая төгрөгийн төлбөрийн актыг хөнгөлж өгнө үү. Хөөн хэлэлцэх хугацаа дууссан” гэсэн хүсэлтийг ирүүлжээ.	Саналыг хүлээн авч, 2014-2015 онд тогтоосон төлбөрийн акт 3.6 сая төгрөгийг чөлөөлж, 0.7 сая төгрөгөнд төлбөрийн акт тогтоосныг хэвээр үлдээлээ.
2	Хөрөнгө оруулалтыг ажлыг гэрээт хугацаанд хүлээлгэн өгөөгүйд 2.63 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон , үүнийг тухайн компаниас тооцож авах боломжгүй байна” гэжээ	Гэрээ байгуулахдаа 2 тал харилцан хугацааг тохиролцон байгуулдаг. Хэрвээ хугацаандаа нийлүүлэх боломжгүй байсан бол үндэслэлтэй хүсэлтийг харгалзан үзэж, гэрээг сунгаж болно. Эдгээр ажлуудын гэрээнд сунгалт хийгдээгүй учир актыг чөлөөлөх боломжгүй юм.
3	Минпро ХХК-аас 10.0 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан боловч, анхан шатны баримтгүй, няравын тайланд орлого аваагүй шууд зардалд бичсэн зөрчилд тогтоосон төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Учир нь ЭХЯ-ны 95 жилийн ойд бэлэг дурсгалын зүйлийг бэлтгэж өгөх үүрэг өгөгдсөний дагуу гэрээ байгуулж, гэрээг үндэслэн шууд зардалд бичсэн гэжээ. Одоо дахин орон нутгийн төсөвт 10.0 сая төгрөг төлөх боломжгүй байна.	Минпро ХХК-тай байгуулсан “Худалдан авах гэрээ”-нд шууд зардалд бичих талаар ямарч заалт байхгүй бөгөөд өгч байгаа тайлбар нь үндэслэлгүй тайлбар байна. Учир нь гэрээний 2 дахь хэсгийн 2.1-д <i>/гэрээний 1.1-д заасан бэлэг дурсгалын зүйлийг 2017 оны 10 дугаар сарын 15-ны өдөрт багтаан худалдан авагчид нийлүүлнэ./</i> , 3 дахь хэсгийн 3.2-т <i>/худалдан авагч гэрээний 2.1 заасан хугацаанд худалдагчаас бэлэг дурсгалын зүйлсээ хүлээн авах/</i> гэж заасан нь бэлэг дурсгалын зүйлийг хугацаанд нь хүлээлгэн өгөхөөр заасныг харуулж байна. Тайлбарт “ЭХЯ-ны 95 жилийн ойд бэлэг дурсгалын зүйл бэлдэж өгөх үүрэг өгөгдсөний дагуу” гэсэн байгаа нь ТӨХК нь Төсвийн тухай хуулийн 25.10 дахь заалт <i>/Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно./</i> -ыг, Гүйцэтгэх захирлын хөлсөөр ажиллах гэрээний 3.9 дахь заалт <i>/Гүйцэтгэх захирал ТУЗ-ын зөвшөөрөлгүйгээр компанийн хөрөнгөнөөс зээл олгох, хандивлах, бэлэг өгөх, бусдад хөрөнгийн баталгаа гаргахыг хориглоно/-</i> ыг зөрчсөн байна.
	УИХ-ын тогтоолыг зөрчин 2016-2017 нд 82.4 сая төгрөгийн шинэ жил, баяр, ойн арга хэмжээнд үр ашиггүй зарцуулсан нь ТУЗ-өөс батлагдсан зардлын дагуу, хамтын гэрээнд заагдсан заалтыг үндэслэн зарцуулсан тул төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөхгүй гэжээ. Мөн ахмадын баяр, хүүхдийн баярын арга	Системийн хэмжээнд 136.0 сая төгрөгийг баяр ёслолын үйл ажиллагаанд зарцуулсан ба төлбөрийн акт тогтоохдоо ахмадын баяр, хүүхдийн баяр, эрчим хүчний ажилчдын өдөр, март 8 зэрэг баярт зарцуулсан зардлыг оруулаагүй, харин шинэ жил, ойн арга хэмжээнд зарцуулсан 82.4 сая төгрөгөнд төлбөрийн акт тогтоосон байсан. Эдгээрийг хамтын гэрээ, ТУЗ-ын шийдвэр зэргийг харгалзан үзээд ой, эмэгтэйчүүдийн баярын арга



	хэмжээнд зарцуулсан зардал нь хуулийн дагуу зарцуулагдсан гэжээ.	хэмжээнд зарцуулсан 55.5 сая төгрөгийг албан шаардлагаар хүргүүлж, 27.4 сая төгрөгөнд төлбөрийн акт тогтоохоор оруулж байна. Энэ нь МУ-ын Их хурлын 2016 ны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 47 дугаар тогтоолын в.5 дахь заалт /төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх / заалтыг зөрчсөн байна. Мөн хамтын гэрээнд заагаагүй санхүүчдийн баярт зарцуулсан 0.52 сая төгрөгөнд төлбөрийн акт тогтоосон.
5	Жолоочийн шатахууны замын хуудас бичээгүй, тооцоо бодоогүй ажлын хариуцлага алдсан жолооч нар дээр хариуцлага тооцох албан шаардлагыг зөрчил арилгах албан шаардлага болгож өгөх	Жолоочийн тооцооны замын хуудас бичсэн боловч шатахууны дутагдал гаргасан зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Гэвч огт хөтлөөгүй албан тушаалтанд хариуцлага тооцохгүй байх нь шударга бус бөгөөд цаашид ажилдаа хариуцлагатай хандах нь зайлшгүй юм. Иймд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодогч, жолоочийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн зөрчилд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.13-т заасныг үндэслэн хариуцлага тооцох саналыг хүргүүлсэн.
6	Эд хөрөнгийн тооллого хийхэд 517.1 мянган төгрөгийн бараа материал дутагдлаа.	Аудит 2018 оны 06 сарын 11-нд нээлтээ хийн, албан ёсоор эхэлсэн. Бид аудитыг гүйцэтгэхдээ гүйцэтгэлийн аудитын журам, стандартад нийцүүлэн тулган баталгаажуулах горим сорил хэрэгжүүлэн, биет тооллогыг хийж гүйцэтгэсэн. Тооллогыг 2018 оны 08 сарын 28-ны өдөр хийсэн бөгөөд эрх бүхий албан тушаалтнаар зөвшөөрүүлж, гарын үсэг зуруулаагүй 69.9 мянган төгрөгийн шаардах байсныг хасч тооцсон. Иймд дутагдсан БМ-н дүнд бүрдэл дутуу шаардахаар зарцуулсан БМ ороогүй болно.
II	“Богдын голын УЦС” ХХК	
1	Эд хариуцагч Б.Сэвжидмаад 7,150.0 мянган төгрөгөөс татвар суутгаагүй зөрчил 10% буюу 715.0 мянган төгрөгөнд төлбөрийн акт тогтоосон. Үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байна гэжээ.	“Богдын голын УЦС”-ын 20 жилийн ойтой холбоотой гарсан зардал бөгөөд бэлтгэн нийлүүлэгчийн дансаар шилжүүлээгүй нь татвараас зайлсхийсэн үйл ажиллагаа бөгөөд хуулийн дагуу төлбөрийн акт тогтоосон. Уг зөрчил бусад байгууллага дээр мөн илэрсэнд төлбөрийн акт тогтоосон.